



Нээлтэй  
Нийгэм  
Форум

ИМПОРТЫН УРЬДЧИЛСАН ХЯНАЛТЫН  
ТОГТОЛЦООГ ИНСТИТУТЧИЛАХ ЗАМААР  
**ХҮНСНИЙ ЧАНАРЫН  
БАТАЛГААГ ХАНГАХ НЬ**

---

Бодлогын судалгааны тайлан

**Бодлогын судлаач:** **Б.Арвинбаяр**

2007 оны Бодлогын судалгааны тэтгэлэгт  
хөтөлбөрийн судлаач, ШУТИС-ийн багш

**Судалгааны шүүмжлэгч:** **А. Бакей**

УИХ-ын гишүүн, Эдийн засгийн ухааны  
доктор

Улаанбаатар хот, 2007 он

DDC  
336.2  
Ф-824



## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

**Хаяг:** Жамъян гүний гудамж 5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар -48, Монгол улс

**Утас:** 976-11-313207

**Факс:** 976-11-324857

**Вэб:** [www.forum.mn](http://www.forum.mn)

**И-мэйл:** [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Уг судалгаагаар гаргасан дүгнэлт саналууд нь  
судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын  
хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Энэ судалгааны тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст  
хямдралтай үнээр худалдана.

ISBN 978-99929-56-37-2

## ► ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	4
ХУРААНГУЙ .....	5
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО .....	9
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	10
1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН .....	12
1.1. Хүнсний аюулгүй байдал гэдэгт юуг ойлгох вэ? .....	12
1.2. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын түвшин.....	13
1.2.1. Хүнсний хангамж, хүртээмж .....	13
1.2.2. Хүнсний чанарын баталгаат байдал .....	16
1.2.3. Хүнсний шимт чанар.....	17
1.3. Дэлхийн улс орнуудын явуулж буй жишиг бодлого, туршлага.....	18
2. МОНГОЛ ДАХЬ ИМПОРТЫН ХҮНСНИЙ ЧАНАРЫН БАТАЛГАА: ЭРХЗҮЙН ОРЧИН, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО.....	24
2.1. Хүнсний чанарын баталгааг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчин.....	24
2.2.Хилийн бүртгэл, хяналтанд тулгуурласан тогтолцоо .....	28
2.3.Импортын хүнсний урьдчилсан хяналтын тогтолцоо.....	30
3. УРЬДЧИЛСАН ХЯНАЛТАНД ТУЛГУУРЛАСАН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМУУД.....	34
3.1. Хилийн болон урьдчилсан хяналтанд тулгуурласан хяналтын тогтолцооны хувилбаруудын харьцуулалт.....	34
3.2.Олон нийтийн хяналт, оролцооны механизмууд .....	36
4. ДҮГНЭЛТ .....	37
5. ЗӨВЛӨМЖ.....	41
6. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД .....	44
7. НОМЗҮЙ.....	52

## ► ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ХХААЯ</b>	Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
<b>УМХГ</b>	Улсын Мэргэжлийн Хяналтын Газар
<b>ЭМЯ</b>	Эрүүл Мэндийн Яам
<b>БОЯ</b>	Байгаль орчны Яам
<b>ДЭМБ</b>	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
<b>ХМХА</b>	Хилийн Мэргэжлийн Хяналтын Алба
<b>СХҮТ</b>	Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Төв
<b>ЭМХҮТ</b>	Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв
<b>НЭМХ</b>	Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
<b>ҮСГ</b>	Үндэсний Статистикийн Газар
<b>ШБӨХЗГ</b>	Шударга Бус Өрсөлдөөнийг Хянан Зохицуулах Газар
<b>УГЕГ</b>	Улсын Гаалийн Ерөнхий Газар
<b>ХЭАХН</b>	Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг
<b>CFIA</b>	Канадын Хүнсний Хяналтын Алба
<b>EFSA</b>	Европын Холбооны Хүнсний Аюулгүй Байдлын Байгууллага
<b>FAO</b>	НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
<b>FDA</b>	АНУ-ын Хүнс Эмийн Алба
<b>IFPRI</b>	Олон улсын Хүнсний Бодлогын Судалгааны Хүрээлэн
<b>GMP</b>	Зохистой үйлдвэрлэлийн дадал, хэм хэмжээ
<b>GAP</b>	Зохистой газар тариалангийн дадал, хэм хэмжээ
<b>НАССР</b>	Эгзэгтэй цэгийн хяналтын шинжилгээ

## ► ХУРААНГУЙ

Хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 хувийг импортоор авч буй манай улсын хувьд хүнсний хангамж, чанарын аюулгүй байдлыг хангах нь хөндүүр сэдвийн нэг болжээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал” гэсэн 9-р бүлэгт хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийг тодорхойлохдоо:

- *гадаад худалдааны бодлого, импортын барааны чанарт тавих хяналт суларч алдагдсаны улмаас хүн амын эрүүл мэнд, удамшилд сөргөөр нөлөөлөх хоол хүнс, химийн болон өргөн хэрэглээний бараа орж ирэх;*

гэжээ. Дээрх дүгнэлтэд (импортын) хүнсний бүтээгдэхүүний чанарт тавих хяналтыг хүн ам, улс үндэстэнд үзүүлэх урт хугацааны эрсдэлийн үүднээс тайлбарласан нь оновчтой хандлага болж чадсан байна.

Монгол Улс өнөөдөр стратегийн<sup>1</sup> (мах махан бүтээгдэхүүнээс бусад) хүнсний бүтээгдэхүүнийхээ дийлэнхи хувийг импортоор авч байгаа нь хүнсний хангамжийн аюулгүй байдал алдагдсан буюу гадаад улсаас хүнсний хараат байдалтай болсоныг харуулж байна. Хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцооны бүрдэл хэсгүүд уялдаа холбоо муутай, нэгдсэн бүртгэлийн систем бүрэлдээгүй, гарал үүслийн талаар системтэй мэдээлэлгүй, шошгогүй оруулж байгаа зэрэг нь хүнсний тогтвортой хангамж, чанарын баталгаат байдалд сөргөөр нөлөөлж байна.

Манай улсад импортын хүнсний бүтээгдэхүүний хяналтын талаар тусгайлан гаргасан хууль эрхзүйн акт байхгүйн дээр холбогдох хууль эрх зүйн актуудад хүнсний аюулгүй байдлын асуудлыг хөндсөн

<sup>1</sup> Стратегийн хүнсний бүтээгдэхүүн гэж хүн амын өргөн хэрэглээний гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг хэлнэ.

зарим зүйл заалтуудын хоорондын уялдаа холбоо муу байна. Хүнсний чанарын баталгаат байдлыг тухайлан хариуцсан төрийн бүтэц байхгүй, энэ нь салбарын яамдын (ХХААЯ, ЭМЯ, УМХГ) дундын асуудал болсон бөгөөд зарим холбогдох төрийн байгууллагын (ҮХЯ, СХҮГ) чиг үүрэг тодорхойгүй орхигджээ.

Дэлхийн худалдааг хөнгөвчлөх глобаль чиг хандлага, импортын татварын нэн тааламжтай нөхцөл зэрэг нь манай улсын хүнсний хангамжийг сүүлийн 10-аад жилд эерэг тал руу нь өөрчилсөн боловч хүнсний чанарын баталгаат байдал, хоол хүнсний шимт чанарын асуудал төдийлөн яригдахгүй орхигдсоор байгаа нь хүн амын худалдан авах чадвараас шалтгаалсан нөхцөл гэж тайлбарлах нь элбэг. Гэвч хүнсний гаралтай өвчлөл нэмэгдэх, болсон нь өнөөдөр хүнсний чанар, шимт чанарт нухацтай анхаарах цаг болсныг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад чанар муутай болон бохирдсон хүнсний бүтээгдэхүүнээс үүдэлтэй өвчлөлийн тоо, ихээхэн нэмэгдсэн байх таамаглал байгаа ч энэ чиглэлийн судалгаа, ялангуяа импортын хүнсний бүтээгдэхүүн, хүний эрүүл мэндтэй холбогдох нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийгдээгүй байна. Нөгөө талаар хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх систем сул хөгжсөн, тээвэрлэлтийн сүлжээний нэвтрүүлэх чадал, хүрэлцээ муу байгаа нь импортоор оруулж ирж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Импортын хүнсний дийлэнхи хувийг жижиг аж ахуйн нэгжүүд, ганзагын наймаачид нийлүүлж байгаа нь хүнсний чанарт цэгцтэй, баталгаатай хяналт тавих боломжийг алдагдуулж байна. Хүнсний аюулгүй байдал баталгаажсан дэлхийн улс орнуудад хүнсийг ганзагын наймаагаар оруулах ойлголт огт үгүй бөгөөд манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг дээдлэх үүднээс эдийн засгийн арга механизмаар ганзагын наймааг хязгаарлах, цаашдаа таслан зогсоох шаардлагатай. Эдийн засгийн хөшүүргийг ашиглан чанарын баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх дунд болон томоохон аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас олгох, мөн олон нийтэд хүнс импортлогч аж ахуйн нэгжүүдийн талаар нээлттэй мэдээлэл өгч, хөндлөнгийн хяналтыг бий болгох зэрэг бодлогын тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зарим нэг стратегийн хүнсний бүтээгдэхүүний (гурил) импортын зах зээлд дээр монополь аж ахуйн нэгжүүд давамгайлж байгаа нь шударга бус өрсөлдөөнийг бий болгож, улмаар үнийг хөөрөгдөн өөрийн дураар тогтоох нөхцөл боломжийг олгон, эцэстээ хүнсний хангамж, хүртээмжид сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд хүн ам цөөтэй манай орны хувьд өрсөлдөөнийг дэмжих, монополийг хязгаарлах зорилгоор олигополь<sup>2</sup> буюу хэд хэдэн нийлүүлэгчдээс хамаарсан импортын хүнсний хангамжийг дэмжих бодлого чухал байна.

Импортын хүнсний аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тухайд манай орны хувьд хил, гүний мэргэжлийн хяналтанд төвлөрсөн буюу хилээр нэгэнт орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг хянах шалгах тогтолцоо үйлчилж байна. Энэ нь системтэй хяналтыг бүрэн хийх бололцоо олгохгүй, эсвэл хүнд суртал, хээл хахуулийг даамжруулах нөхцөл болж улмаар стандартын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн орж ирэхээс сэргийлж чадахгүйн дээр олон улсын худалдааг хөнгөвчлөх зарчимтай зөрчилдсөн шийдэл болж байна. Дэлхийн өндөр хөгжсөн улс орнуудад болон манай хөрш Оросын Холбооны улс, БНХАУ-д хэрэгжүүлж буй импортын хүнсний урьдчилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлснээр манай улс импортын хүнсний аюулгүй байдлаа баталгаажуулж чадна гэж үзлээ.

Эдийн засгийн шилжилтийн үед хүнсний хангамж доголдож байсан он жилүүдэд бүрэлдсэн зохицуулалтгүй хүнсний импортыг хянах хил гаалийн хяналтанд тулгуурласан одоогийн тогтолцоог халж, хөрш улсууд, бүсийн хэмжээний хамтын ажиллагааг ашиглах боломж олгосон тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болжээ.

Импортын хүнсний урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцоо нь гадаадын үйлдвэрлэгч, дотоодын нийлүүлэгч хоёр талд хариуцлага хүлээлгэх давуу талтай бөгөөд хүнсний бүтээгдэхүүнийг урьдчилан тохиролцсоны үндсэн дээр үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчээс эхлэн хил гаалиар дамжуулан хэрэглэгчдэд хүргэх хүртэлхи шат дамжлага, замыг хяналт бүртгэлтэй болгодог үр дүнтэй механизм юм. Дээрхитэй холбоотойгоор импортын хүнсний бүтээгдэхүүний стандарт,

<sup>2</sup> Нэг төрлийн бүтээгдэхүүнийг хэд хэдэн компани зах зээлд нийлүүлэх буюу үйлдвэрлэж буйг хэлнэ. <http://www.basiceconomics.info/oligopoly-market-structure.php>

тохирлын үнэлгээ болон лиценз олголтыг олон улсын болон бүс нутгийн хэмжээнд тохиролцон хэрэглэх боломж үүсэх бөгөөд энэхүү стандарт, үнэлгээний дагуу хүнсний бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулахад шаардлагатай шинжилгээний тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгцээ, хүний нөөцийг сайжруулах шаардлагыг мөн л бүс нутаг, хөрш улсуудын хамтын ажиллагааны хүрээнд шийдэх боломж нэмэгдэх юм. Учир нь хүнсний чанарын баталгаа баримтууд, үнэлгээний үйл явцыг хөрш улсууд, бүс нутгийн хэмжээнд нэгдсэн стандарттай болгосон тохиолдолд гадаад хамтын ажиллагааны хүрээнд богино хугацаанд бидэнд дутагдалтай байгаа техникийн хүчин чадал болон хүний нөөцийг чадавхийг нөхөх, дунд болон урт хугацаанд хүнээ сурган бэлтгэх, хяналт, бүртгэлийн тогтолцоогоо бүрдүүлэх туршлага, дэмжлэгийг дайчлах боломжтой болох юм.

Дэлхийн бусад улсуудад байдаг нийтлэг жишгийн дагуу холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллагуудыг хяналт шалгалтанд татан оруулах механизмуудыг хуульчлах, тэдний оролцоог нь урамшуулан дэмжих нь хяналтын үр дүнг улам бүр дээшлүүлнэ.



## ► СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү бодлогын судалгааны зорилго нь хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 орчим хувийг гадаад улсаас авч буй манай улсад импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих чанарын хяналтыг баталгаажуулахын тулд урьдчилсан хяналтын тогтолцоог шаардлагатай гэж үзэж, уг тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ, боломжийг судлахад оршисон.

Дээрхи зорилгод хүрэхийн тулд дараахи зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль эрхзүйн орчинд дүн шинжилгээ хийх,
- Хүнсний бүтээгдэхүүн импортлох үйл явцад хяналт тавих өнөөгийн тогтолцооны зарчим, бүтцийг дэлхийн бусад улс орнуудын туршлага, ялангуяа урьдчилсан хяналтын тогтолцоотой харьцуулан судлах,
- Урьдчилсан хяналтын тогтолцоог манай улсад бүрдүүлэх хэрэгцээ, боломжид үнэлгээ дүгнэлт өгсний үндсэн дээр төрийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдэд хандсан бодлогын зөвлөмж боловсруулах, зэрэг болно.

## ► СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Тус бодлогын судалгааны дээрх зорилтуудыг хангах үүднээс судалгааны дараах аргуудыг ашиглан шаардлагатай мэдээллийг гаргаж авлаа. Үүнд:

- Баримт бичгийн контент анализын аргаар хууль, эрх зүйн баримтууд, өмнө хийгдсэн судалгааны тайлан, хэвлэмэл материалыг судлах,
- Хилийн боомтууд дээр ажиглалт, ярилцлагын аргаар өнөөгийн байдал, хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх,
- Фокус бүлгийн ярилцлагуудаар сонирхогч талуудын байр суурь, үзэл бодол, туршлага зэрэг мэдээллийг гаргаж авах,
- Ганцаарчилсан ярилцлагуудаар тодорхой сонирхогч тал, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийн үнэлгээ дүгнэлт, байр суурь, туршлагыг судлах, зэрэг болно.

### ■ Баримт бичгийн судалгааны хүрээнд

Сэдвийн хүрээнд олон улсын EFSA, FAO, FDA, CFIA, IFPRI байгууллагуудын хүнсний хяналтын талаар баримталж буй бодлогын 10 гаруй баримт бичигт шинжилгээ хийлээ. Мөн манай улсын хууль эрх зүйн актууд болох “Хүнсний тухай хууль”, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Таалийн тухай хууль”, “Амьтан, ургамлын хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал хоол тэжээл” үндэсний хөтөлбөр болон манай улс нэгдэн орсон олон улсын холбогдох конвенциудийн баримтлал, зарчмуудыг судалсан. ННФ-аас судалгааны ажлын хүрээнд хангаж өгсөн Дэлхийн Банкнаас гаргасан хүнсний аюулгүй байдлын талаархи цуврал тайлан материал болон олон улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдээс гаргасан бодлогын судалгааны ном зохиолуудтай танилцсан.

**■ Хилийн боомтууд дээр хийсэн ажиглалт, ярилцлагууд**

Мэдээлэл цуглуулах хээрийн судалгааны ажлын хүрээнд манай улсын хүнсний бүтээгдэхүүний импортын дийлэнхи хувь нь орж ирдэг Алтанбулаг, Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа, БНХАУ-ын хилийн боомт Эрээн хотын хүнсний борлуулалтын үйл ажиллагаанд ажиглалт хийх, холбогдох талуудын төлөөлөлтэй ярилцлага хийсэн болно.

**■ Фокус бүлгийн ярилцлагууд**

УИХ-ын гишүүд, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр бодлого боловсруулагчид, төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний ажилтнууд, мэргэжлийн хяналтын байгууллагын мэргэжилтнүүдийг хамарсан холимог болон дан мэргэжлийн гэсэн чиглэлтэйгээр 6-8 хүнтэй фокус бүлгийн ярилцлагууд 5 удаа зохиов.

**■ Ганцаарчилсан ярилцлагууд**

Судалгааны ажлын эхэнд болон эцэст судалгааны ажлын чиг гаргах, боловсруулсан материалын талаар тодорхой санал зөвлөгөө авах зорилгоор хүнсний аюулгүй байдлын бодлогын чиглэл тодорхойлогчид, төрийн албан хаагчид, мэргэжлийн эксперт зэрэг сонирхогч талуудыг хамруулан бүтэцчилсэн болон хагас бүтэцчилсэн 15 удаагийн ярилцлага хийсэн.

## 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

### 1.1. Хүнсний аюулгүй байдал гэдэгт юуг ойлгох вэ?

ДЭМБ, НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн байгууллага болон Олон улсын судалгааны хүрээлэнгүүдээс гаргасан тодорхойлолтоор хүнсний аюулгүй байдал гэдэг нь дараахи бие биенээсээ хамаарал бүхий гурван үндсэн ойлголтыг багтаадаг байна. Үүнд хүнсний хангамж хүртээмж<sup>3</sup>, хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал<sup>4</sup>, хүнсний шимт чанар зэрэг хамаарна.



<sup>3</sup> Food security

<sup>4</sup> Food safety

Олон улсын холбогдох байгууллагуудаас<sup>5</sup> аль нэг улс орон, бүс нутгийн хэмжээнд хүнсний хэрэглээ, хүн амын эрүүл мэндийн талаархи үнэлгээг гаргахдаа дээрх 3 үзүүлэлтийг заавал хамруулдаг байна. Хүнсний аюулгүй байдал нь аливаа улс орны хүн амын бодлого, удамтай холбоотой үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улс орон бүр хүнсний аюулгүй байдлынхаа талаар бодит үнэлгээг өгөн түүнийг хангах талаар зохих арга хэмжээг авдаг.

## 1.2. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын түвшин

### 1.2.1. Хүнсний хангамж, хүртээмж:

Хүнсний бүтээгдэхүүний хангамж гэдэгт тухайн улс орон стратегийн гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн болох мах, сүү, хүнсний ногоо, жимс жимсгэнээр хүн амаа хангаж чадаж буй эсэх, энэ хангамжаа бие даан өөрийн дотоод хүчин чадлаар гүйцэтгэж байна уу, эсвэл гадаад улс орноос их, бага хэмжээгээр импортлох замаар гүйцэтгэж байна уу гэх мэт асуудлын хамааруулан үздэг. Тухайлбал олон улсын жишгээр тухайн улс хүнсний бүтээгдэхүүнийхээ 30-50 хувийг (зарим судалгаагаар нэг улсаас 20–оос дээш хувийг) гадаад улсаас авч байвал хүнсний хангамжийн хувьд хараат болсон байна гэж үздэг байна. Гэтэл манай улс мах, махан бүтээгдэхүүнээс бусад гурил, будаа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, бүр давсны дийлэнхи хувийг гадаад улс болон хөрш улсуудаас импортлон авч байгаа нь **хүнсний хангамжийн аюулгүй байдал алдагдсан буюу гадаад улсаас хараат байдалтай**<sup>6</sup> болсоныг харуулна.

<sup>5</sup> НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага <http://www.fao.org/publishing/>  
Олон улсын Хүнсний Бодлогын Судалгааны Хүрээлэн [http://www.ifpri.org/pubs/pubs\\_menu.asp](http://www.ifpri.org/pubs/pubs_menu.asp)

<sup>6</sup> Хүнсний хангамжийн байдлыг тодорхойлоход хэрэглэдэг Херфиндаль-Хершманы индексээр (хараат байдлын зэргэмж) тооцон үзэхэд өргөн хэрэглээний гол нэр төрлийн 8 барааны хувьд Монгол улс бүрэн болон үлэмж хараат байдалтай байна.



Бид өнөөдөр үндэсний хэмжээнд хүнснийхээ хэрэгцээг дотоодын үйлдвэрлэл болон гадаад нийлүүлэлтээр хангаж чадаж байгаа нь асуудлын дөнгөж нэг тал нь бөгөөд харин хүртээмж нь хүн амын худалдан авах чадвараас голлон хамаарсан өөр асуудал болдог. Өөрөөр хэлбэл, хүнс хангалттай хэмжээгээр нийлүүлэгдэж байгаа нь хүн болгонд хүнс хангалттай хэмжээгээр хүрч байгаа гэсэн үг биш юм. Манай улсын хүн амын 30 орчим хувь нь буюу 750-800 мянган хүн<sup>8</sup> ядуу, хүнсний хомсдолтой буюу мэргэжлийн байгууллагуудаас зөвлөж байгаа хэмжээнд хүрсэн илч тэжээлийг хоолноосоо авч чадахгүй байгааг мэргэжлийн хүмүүс анхааруулсаар байна.

Ядуурал буурахгүй байгаагийн зэрэгцээ мөн сүүлийн жилүүдэд өрхийн орлогын өсөлт нь өрхийн хүнсний бүтээгдэхүүний зарлагын өсөлтийг гүйцэхгүй байх хандлага тодорхой ажиглагдах болсон

<sup>7</sup> ХХААЯ-ны 2006 оны тайлан мэдээ

<sup>8</sup> ЭМЯ, UNICEF. Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал

(Хүснэгт 1. харна уу). Хүнсний бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс шалтгаалж хүн амын худалдан авах чадвар буурч энэ нь хүнсний хүртээмжид сөргөөр нөлөөлөх боллоо.

<b>Хүснэгт 1. Монгол улсын нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага<sup>9</sup></b>			
<i>(Төгрөг)</i>			
Өрхийн орлого зарлагын төрөл	2002 он	2006 он	2006/2002 оны харьцаа, %
нийт: Орлого	156159	200179	128,2
Үүнээс: өөрийн хувийн аж ахуйгаас бэлтгэсэн хүнсний зүйлс	24801	22420	90,4
нийт: Зарлага	163654	228172	139,4
Үүнээс: Хүнсний зарлага	52204	69293	132,7

Цалингийн өсөлт, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зэрэг бодлогын арга хэмжээний дүнд нэмэгдсэн мөнгөний нийлүүлэлтээс шалтгаалсан хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт манай улсын инфляцийг нэмэгдүүлсэн. 2006 онд малын толгойн өсөлтийн ачаар 210,0 мянган тонн мах бэлдсэн нь махны хэрэгцээг бүрэн хангахаар байсан боловч хангамжийн сүлжээ сул, хадгалах зоорь сав үгүйгээс ялангуяа хот суурин газрын махны хангамж хязгаарлагдмал хэвээр байж, үнийн хэлбэлзэл 50 хувьд хүрч<sup>10</sup> байсан нь инфляцид нөлөөлөх хэмжээнд байсан. Стратегийн хүнсний бүтээгдэхүүний өөр нэг нэр төрөл болох гурилын хувьд улаан буудайн дийлэнхи хувийг (70-80%) ОХУ, Казакстан, БНХАУ зэрэг орнуудаас авч, харин дотоодын буудайны дийлэнхи хувь нь архи спиртийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зарцуулагддаг байна. Энэ салбарт цөөн тооны монополь үйлдвэр улаан буудай, гурилын дийлэнхи хувийг импортлож байгаа нь өрсөлдөөнгүй нөхцөлд шударга бусаар

<sup>9</sup> Эх сурвалж: СТГ, Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2002, 2006.

<sup>10</sup> Статистикийн Төв Газар. Тайлан мэдээ 2005-2007.

үнийг үзэмжээрээ нэмэх боломж үүсгэж, хүнсний хүртээмжийг улам дордуулах магадлалтай. Тухайлбал энэ оны хувьд цаг уурын нөлөөгөөр ургац буурсантай холбогдон дэлхийн хэмжээнд гурилын үнэ 25-40 хувиар өссөн ч манайд үнийн өсөлт 50-80 хувьд хүрсэн нь дэлхийн хэмжээний нөхцөл байдлаар тайлбарлагдахааргүй огцом өсөлт байна.

### **1.2.2. Хүнсний чанарын баталгаат байдал**

Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгаат байдал гэдэг нь хүнсний бүтээгдэхүүнд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэгч өвчин үүсгэгч бичил биетний бохирдолгүй, элдэв химийн бодисын үлдэгдэлгүй байх зохих шаардлагыг хангасан байхыг хэлнэ. Монгол улсад импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд чанарын баталгаатай хүргэх хүртэл тавих хяналт сул, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын нөхцөл туйлын хангалтгүй байгаа нь хүнсний чанарын баталгаат байдлыг улам дордуулж байна. Иймээс хүн амын дундах хоол тэжээлийн гаралтай өвчлөлт, хавдрын тоо хэмжээ нэмэгдэж байгааг эдгээртэй холбон үзэхээс аргагүй. Гэвч эдгээр өвчлөлийг импортын хүнсний бүтээгдэхүүнээс үүдсэн эсвэл үүнтэй холбоотойгоор авч үзсэн нарийвчилсан судалгааны ажил хийгдээгүй байна.

Хүнсэнд голлон хэрэглэж буй махны 5 орчим хувь, сүүний дөнгөж 2,3 хувийг (7,1 сая литр) үйлдвэрлэлийн аргаар боловсруулж, үлдэх хувийг ганзагын наймаагаар хангаж байна. Хадгалалт, тээвэрлэлтийн нарийн горим шаарддаг эдгээр бүтээгдэхүүний хувьд эрүүл ахуйн чанарын баталгааг ганзагын наймааны нөхцөл, дэд бүтэц хангаж өгч чадах нь эргэлзээтэй.

Өнөөдөр Монголд гарч байгаа нийт халдварт өвчний 30 гаруй хувийг хоол хүнс, орчны ариун цэвэр, эрүүл ахуйн стандарт зөрчигдсөнөөс үүсдэг гэдэсний халдварт өвчин, хордлогот халдвар эзэлж байна<sup>11</sup>.

<sup>11</sup> ЭМЯ-аас гаргасан 2006 оны Эрүүл мэндийн тайлан



**Хүснэгт 2. ЭМЯ-наас гаргасан 2006 оны  
«Эрүүл мэндийн тайлан судалгаа»**

Өвчлөлийн нэр	10000 хүнд ногдох тоо	Тайлбар
Хоол шингээх эрхтэний тогтолцооны өвчин	729.63	Эдгээр үзүүлэлт 1996 онтой харьцуулахад 2 дахин, 2000 онтой харьцуулахад 35-50%- иар нэмэгдсэн байна.
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	501.84	

Судалгаанаас үзвэл хүнсний гаралтай бактерийн хордлоготой холбоотой өвчлөл 2005 онд 2003 онтой харьцуулбал 11,2 хувиар нэмэгджээ. 1995-2000 онуудад хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, үүний дотор элэгний хорт хавдар тэргүүлэх болсныг чанарын баталгаагүй хүнстэй холбон үзэж болно. Тэгэхлээр хүнсний гаралтай өвчлөл, нянгийн бохирдоос үүдэлтэй халдвар, тэр ч бүү хэл хавдрын төрлийн өвчлөл нэмэгдэх хэмжээнд хүртлээ манай хүнсний чанарын баталгаа алдагдаад байна.

### 1.2.3. Хүнсний шимт чанар

Шимт чанар сайтай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж чадахгүй байгаагаас болж хүн амын эрүүл мэнд доройтон, хүний биеийн эсэргүүцэл муудаж өвчинд өртөмтгий болж, өсвөр үеийн хүүхдүүдийн өсөлт хөгжил саардаг нь нийгмийн эрүүл мэнд, хүнс тэжээлийн олон судалгаагаар батлагдсан дүгнэлт юм. Жишээлбэл, хөгжиж буй орнуудад сургуулиар дамжуулан “Үдийн хоол”, “Үдийн цай” зэрэг хөтөлбөр хэрэгждэг нь хүүхдийг хоол тэжээлийн доройтлоос хамгаалах, шим тэжээлт хоолоор хангах зорилготой байдаг.

Манай улсад сүүлийн жилүүдэд халдварт болон хавдар, харшил, үе мөчний өвчний тоо эрс нэмэгдсэнийг судлаачид хүнсний шимт чанар алдагдсантай холбон үзэж байна. Манай улсын хүн амын хүнсний хэрэглээнд мах, гурил зонхилж, аминдэм, эрдэс бодисын үндсэн эхүүсвэр болох төмс, хүнсний ногоо, төрөл бүрийн жимс, жимсгэнэ зэргийг хоол хүнсэндээ бага хэрэглэж байна. Аминдэм, эрдэс, биологийн идэвхит

бодисоор баялаг шимт чанартай хүнс хэрэглэж чадахгүйгээс болж хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны элдэв өвчин, ясны сийрэгжилт, эрт өтлөлт зэрэг эмгэгийн тоо хүн амын дунд ихэссээр байна. НЭМХ-ээс гаргасан судалгаагаар монгол хүний хоногийн хоолны илчлэг дунджаар 2200 ккал буюу зөвшөөрөгдсөн дундаж хэмжээнээс<sup>12</sup> бага, уураг 88.6-105.4 гр, өөх тос 77.6-90.1 гр, нүүрс ус 213.8-290.7 гр болж үндсэн шимт бодисуудын хэрэглээний зохистой харьцаа алдагдсан байна. Гэтэл амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүн хоногийн хэрэгцээт илчлэгийнхээ дөнгөж 58.1-68.5 хувийг авч чадаж байгаа нь нэн доогуур үзүүлэлт юм.

Мянганы хөгжлийн зорилтод тодорхойлсон гол үзүүлэлтүүдийн нэг нь 5 хүртэлхи насны хүүхдийн хоол тэжээлийн дуталыг бууруулахыг манай улс чухалчлан үзсэн билээ. Гэтэл НЭМХ-ийн судалгаагаар<sup>13</sup> 5 хүртэлх насны 4 хүүхэд тутмын нэг нь өсөлт хоцорсон, 8 хүүхэд тутмын нэг нь тураалтай, 32.1 хувь нь сульдаатай, 43.6 хувь нь төмөр дутлын цус багадаалттай байгаа нь тогтоогджээ. Энэ нь өрхийн хүүхдийн тоо, амьжиргааны түвшин, эцэг эхийн боловсрол, төрөлтийн жин зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг боловч бид дээрхи зорилтыг хангах үүднээс шимт чанартай хүнс тэжээлээр хангах бодлогын олон чухал арга хэмжээг авах шаардлагатай байгааг харуулж байна.

### 1.3. Дэлхийн улс орнуудын явуулж буй жишиг бодлого, туршлага

Хөгжлийн түвшин өндөртэй улс орнууд хүнсний бүтээгдэхүүний чанар болон чанарын баталгаандаа тууштай анхаарч, дараах 3 стратегийн чиглэлд бодлогоо төвлөрүүлж байна. Үүнд:

- A. *Үйлдвэрлэгчээс<sup>14</sup> хэрэглэгч хүртэлхи хүнсний хангамжийн сүлжээний алхам бүрт нь чанарын хяналт тавих үүрэгтэй бүтцийг бий болгох:*

<sup>12</sup> ЭНҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллагаас нэг хүн хоногт дунджаар 2500 ккалори илчлэгтэй хүнс хэрэглэхийг зөвлөж байна. <http://www.fao.org/>

<sup>13</sup> ЭМЯ, UNICEF. Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал

<sup>14</sup> Үйлдвэрлэгч гэдэгт тухайн хүнсний бүтээгдэхүүний түүхий эд үйлдвэрлэгч нийлүүлэгчээс авахуулаад хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг оруулж ойлгодог.

АНУ, Европын холбооны улсуудад хүнсний бүтээгдэхүүн, эм, малын тэжээлийн хяналт бүртгэлийг хийх, чанарын баталгаат байдлыг хангах чиг үүргийг холбооны үндэсний хэмжээний тодорхой нэг бүтэц гүйцэтгэдэг нь хяналтыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх боломж олгодог. АНУ-д хүнсний аюулгүй байдлыг Холбооны засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг FDA түүний салбар байгууллагууд хариуцдаг бөгөөд энэ байгууллага нь хүний идэж ууж, хэрэглэх бүхий л зүйл буюу эм, хүнс, ундны усны эрүүл ахуй, чанарын аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээдэг, Умард Ирланд, Их Британий Нэгдсэн Хаант Улсад ийм бүтцийн байгууллага нь Эрүүл мэндийн сайддаа шууд харъяалагддаг бол Дани, Канад улсад Хүнс Хөдөө Аж Ахуйн яаманд хариуцуулдаг нь хүнсний чанарын аюулгүй байдлын зохицуулалтанд эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарын тухайн улсад үзүүлэх жин, нөлөөллөөс хамааран ялгаатай байдаг оршино. Европын Холбооны хүрээнд 2002 онд Европын Комиссын дэргэд байгуулагдсан EFSA нь энэ чиг үүргийг гүйцэтгэдэг. EFSA-ийн онцлог нь дэргэдээ мэргэжлийн болон эрдэмтдийн гэсэн хоёр зөвлөх танхимийг ажиллуулдаг ба эдгээр нь стандартад үнэлгээ өгөх, зах зээлд шинээр нэвтэрсэн бүтээгдэхүүнд эрсдлийн болон аюулгүй байдлын үнэлгээ гаргах үндсэн үүрэгтэй ажилладаг.

Дээрхи байгууллагын тэргүүнүүд нь тухайн улсынхаа Эрүүл ахуйн ерөнхий эмч гэсэн статустай болдог байхад манай улсад ийм албан тушаал байхгүй байна. Монголд ХХААЯ үр тариа, гурилаас бусад асуудалд ихэвчлэн дотоодын хүнсний хангамжийн асуудалд голлон анхаардаг. ЭМЯ нь эмийн хяналтаас гадна, хүнсний эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах журам заавар гаргах үүрэгтэй болж, хүнсний чанарыг баталгаажуулах, бодлогын хувьд хянах асуудалд хамааралгүй болсон ажээ. Харин хяналт, шалгалт хийх үүрэг нь УМХГ-т очжээ. Ингээд хүнсний чанарыг тодорхойлсон стандарт журам боловсруулан мөрдүүлэх, хэрэгжилтийг хяналт тавих зэрэг асуудлыг салбаруудын дунд хувааж хариуцуулснаар уялдаа холбоо суларч, эцэстээ чанартай хоол хүнсээр монголчуудыг хангах асуудлыг цогцоор нь зохицуулах бодлогогүй, хариуцах эзэнгүй болжээ.

Хөгжингүй орнуудад шилжмэл гентэй хүнсний тухай, гуравдагч орнуудаас бүтээгдэхүүн нийлүүлэх тухай, биологийн идэвхит нэмэлт хүнс, мах, сүү, ногоо, жимс, загасны мах, өндөг, эмийн бүтээгдэхүүний тухай гэх мэтчилэн хүнс, эмийн төрөл зүйл тус бүрээр эрхзүйн акт гаргадаг бөгөөд Европын Холбооны улсуудын хувьд 2002 онд батлагдсан

Хүнсний тухай хууль нь тулгуур эрх зүйн баримт болж байна. Харин АНУ-д 2002 онд батлагдсан Биотерроризмын тухай хууль нь импортын хүнс, эмийг АНУ-ын зах зээлд хэрхэн гаргах талаар дэлгэрэнгүй удирдамжийг гарган өгчээ. FDA нь АНУ-д жилдээ хэрэглэгдэх 417 тэрбум долларын дотоодын, 49 тэрбум долларын (2007 оны байдлаар) импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хянан зохицуулж байдаг. 2007 оны 11 сард FDA-аас Хүнсний аюулгүй байдлыг хангах Үндэсний шинэ хөтөлбөр<sup>15</sup> гаргаж хүнсний талаар шинэ бодлого баримтлах болсоноо зарлажээ. Энэхүү шинэ бодлого<sup>16</sup> нь одоогийн өндөр зардалтай хил дээрхи хяналт шалгалтын тогтолцооноос импортын хүнсний нийлүүлэлтийн гинжин хэлхээг бүхэлд нь хянах, импортлогч, нийлүүлэгч талуудад хариуцлага хүлээлгэх, тэдэнтэй хамтран ажиллах, хүнсний хяналтыг гүйцэтгэх холбогдох байгууллагуудын хамтын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох тогтолцоонд шилжихэд чиглэж байна.

Европын холбооны болон АНУ-ын хууль эрхзүйн актуудад зааснаар зах зээлд хүнс, эмийн бүтээгдэхүүнийг импортоор оруулахад дараахи зүйлсийг урьдчилан нарийн зааж мэдэгдэх шаардлагатай болсон байна.

Үүнд:

- Хуулийн этгээдийн бүртгэл нэр хаяг
- Албан хүсэлт
- Шаардлагатай гэж үзвэл бүтээгдэхүүнд шинжлэх ухааны үндэслэлтэй эрсдлийн үнэлгээ хийх
- Нэвтрүүлэх хилийн боомт болон замын чиглэл заах
- Нэвтрэх хугацаа
- Бүтээгдэхүүний савлалт, шошгожилт, баталгаат байдлын мэдээлэл
- Бүтээгдэхүүний тоо хэмжээ
- Бүтээгдэхүүний загвар дээж
- Тээвэрлэх хэрэгслийн төрөл
- Бүтээгдэхүүний гэрчилгээний загварууд, танилцуулга
- Электрон баримт бичиг бүрдүүлэлтээрэг орно.

Хүнсний бүтээгдэхүүн импортоор оруулж ирэхийн хангах ёстой эдгээр шаардлагад дүн шинжилгээ хийж үзвэл гарал үүсэл, үндсэн үзүүлэлтүүд нь тодорхой бүтээгдэхүүнийг ямар нөхцөлтэйгөөр хэрхэн оруулж

<sup>15</sup> FDA - Food protection plan 2007

<sup>16</sup> <http://www.importsafety.gov/report/strategicframework/index.html#conclusion>

ирж байгаа нь урьдаас тодорхой байхын зэрэгцээ тээвэрлэлтийн нөхцлийг мөн төлөвлөсөн байх ажээ. Бүтээгдэхүүнийг хилээр оруулж ирэхээсээ өмнө дээрх бүх асуудлыг төлөвлөсөн байхаас гадна бараа, бүтээгдэхүүнийг солигдохоос сэргийлж савлалт, шошгожилтыг хүртэл нарийн зохицуулсан байх шаардлагатай болно.

Эдгээр өндөр хөгжсөн орнууд, ялангуяа АНУ-д хүнсний дотоодын үйлдвэрлэл нь хүнсний хэрэгцээний нэлээд хэсгийг хангадаг, хүнсний аюулгүй байдлыг хянах техникийн болон хүний нөөцийн чадавхи, хүчин чадал өндөр тул хүнсний чанарыг нэлээд өндөр түвшинд баталгаажуулж чаддаг.

*В. Ил тод, нээлттэй хамтын ажиллагааг дэмжих, шийдвэр гаргах явцад талуудын<sup>17</sup> оролцоог хангах:*

АНУ, Европын холбооны улсуудад баримталж буй хүнсний чанарын баталгааг хангахад чиглэсэн бодлого нь зөвөлгөө, сурталчилгаагаар дамжуулан урьдчилан сэргийлэх зорилгоо хангах, хяналт шалгалтыг хамтран ажиллагаа, иргэдийн оролцоогоор дамжуулан хэрэгжүүлэх зарчмыг голчилж байна. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтад оролцож байгаа талууд хэрэглэгчийн гар дээр тавих бүтээгдэхүүнийхээ төлөө хариуцлага хүлээх нөхцөл бүрэлдэж, мэдээлэл сурталчилгааны ачаар иргэд, хэрэглэгчийн мэдлэг, мэдээлэл нэмэгддэг байна. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ISO 9000, ISO 14000 стандартууд, GMP, GAP үйлдвэрлэлийн хэм хэмжээг нэвтрүүлсэн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг бусад улс орнууд дотоодынхоо зах зээлд дэмжин нэвтрүүлдэг. Экспортлогч талууд сайн дураараа хүлээн зөвшөөрч нэвтрүүлдэг эрүүл ахуйн чанарын хяналтын НАССР тогтолцоо нь мөн л тухайн аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөлөөтэй. Илүү нээлттэй, хамтын ажиллагааны орчинд иргэд, хэрэглэгчдэд хүрэх мэдээлэл, сурталчилгааны хэмжээ нэмэгдэхийн хэрээр тэд дээрх олон улсын чанарын стандартуудын талаар мэддэг болдог, ийм бүтээгдэхүүний борлуулалт, түүний үйлдвэрлэгч, импортлогчид итгэх итгэл нэмэгддэг байна.

Хил гаалийн хяналтанд электрон баримт бичиг бүрдүүлэх ажлыг эрчимтэй нэвтрүүлж байгаа нь мэргэжлийн хяналт, гаалийн ажлын

<sup>17</sup> Талууд гэдэг нь үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгч, олон нийтийг хэлнэ.

уялдаа холбоог түргэсгэж, өсөн нэмэгдэж буй гадаад худалдааг хөнгөвчилж, түргэн шуурхай болгож байна. Хүнсний бүтээгдэхүүнийг өөрийн хэл дээр шошгожуулсан тохиолдолд л эдгээр улсууд өөрийн хилээр нэвтрүүлдэг. Энэ нь тухай бүтээгдэхүүнийг тухай үнэн зөв, бодитой мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх худалдан авагчийг эрхийг хангахын төлөө хүлээлгэж буй хариуцлага юм. Төрийн хяналтын байгууллагууд бүтээгдэхүүний хэрэглээний талаар олон нийтийн зөв мэдлэг, хандлага, дадлыг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх нь хэрэглэгчдийн сонголт хийх эрхийг хангах бас нэг арга хэмжээ юм.

*С. Нийгмийн эрүүл мэндийн бодлогуудтай уялдуулах:*

Дээрхи бодлогын үр дүнд хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтэнд өөрчлөлт гарч байгаа эсэхийг тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжин гаргаж байх нь цаашдын бодлогыг тодорхойлох, үр дүнг үнэлэхэд чухал үүрэгтэй байдаг байна. Манай улсад ийм үнэлгээ хийгдэхгүй байгаа нь оношлогоо шинжилгээний хүчин чадал, туршлага дутаж байгаагийн илэрхийлэл гэлтэй.

Иргэдийн амь нас, эрүүл мэндээ хамгаалах эрхийг мэдээлэл авах эрхээр нь дамжуулан давхар баталгаажуулж өгсөн ардчилсан улс орнуудад хүнсний болон хүнс, биологийн гаралтай аливаа гэнэтийн осол, олныг хамарсан өвчлөлийн тохиолдолд шуурхай мэдээлэх, хариу арга хэмжээ авдаг механизмыг бүрдүүлэхэд чухал анхаарал тавин ажиллаж байна (PIR<sup>18</sup>). Шуурхай мэдээлэх нь болзошгүй тархалтаас өөрийгөө хамгаалах арга хэмжээ авах боломжийг иргэдэд олгодог бол хариу арга хэмжээ нь зайлшгүй гүйцэтгэх ёстой төрийн чиг үүрэг гэж үздэг байна.

Дэлхийн Банкны судалгаагаар буурай хөгжилтэй, ядуу орнууд хүнсний хангамж, чанарын аюулгүй байдлыг хангах техникийн болон хүний нөөцийн чадавхи дутмаг байдаг нь тогтоогджээ. Иймээс олон улсын мэргэжилтнүүд эдгээр улсад бүс нутгийн олон талт хамтын ажиллагааг өрнүүлэх, хөрш зэргэлдээ улсуудад ижил стандартыг хэрэгжүүлэх замаар төрөлжүүлэн дагнах, бие биеийнхээ хүчин чадал, хөрөнгө нөөцийн дутагдалтай талуудыг нөхөн гүйцэлдүүлэх, хүнсний гаралтай

<sup>18</sup> FDA Food protection plan - PIR – Prevention, Intervention, Response- Урьдчилан сэргийлэх, Арга хэмжээ авах, Хариу үйлдэл үзүүлэх

Өвчний мониторингийг олон улсын хамтын төслийн хүрээнд гүйцэтгэх зэрэг үр дүнтэй аргуудыг санал болгосон байдаг. Буурай хөгжилтэй улс орнуудын лаборатори, хүний нөөцийн хүчин чадал нь хязгаарлагдмал тул шинээр үүсэж байгаа хүнсний гаралтай өвчин үүсгэгчид, химийн хорт бодисын үлдэгдэл зэргийг хэмжин илрүүлэхдээ олон улсын, бүс нутгийн болон экспортлогч орны итгэмжлэгдсэн лабораториудтай гэрээ байгуулан хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэн баталгаажуулдаг үр ашигтай шийдэл байдаг. Гэхдээ энэ боломжийг ашиглахын тулд стандарт, хэм хэмжээнүүд нь маш тодорхой болсон байх шаардлагатай.

## 2. МОНГОЛ ДАХЬ ИМПОРТЫН ХҮНСНИЙ ЧАНАРЫН БАТАЛГАА: ЭРХЗҮЙН ОРЧИН, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

### 2.1. Хүнсний чанарын баталгааг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчин

Монгол улсын хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, зохицуулахад чиглэсэн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Хүнсний тухай”, “Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай”, “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай”, “Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай”, “Хувиргасан амьд организмын тухай”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулиуд, “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр” зэрэг хууль эрх зүйн актууд үйлчилж байна.

#### Хүснэгт 3. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль эрх зүйн баримтуудын товч агуулга

Хуулийн нэр	Хуулийн зорилт	Хүнсний чанарын баталгааг байдлыг хангах асуудалтай хэрхэн холбогдож байгаа нь
Хүнсний тухай хууль	Хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах	Тус хуулийн «Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоо» гэсэн 4-р бүлэгт хяналтын албад, улсын байцаагч нар хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх замаар чанарын баталгааг хангах тогтолцоог бүрдүүлэхээр заагджээ.



Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах	Энэхүү хуулинд амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн үүний дотор хүнсний бүтээгдэхүүнийг хил гаалиар нэвтрүүлэх үеийн чанарын баталгаат байдлыг хангах, хянах зүйл заалтууд орсон ба манай улсын хилийн болон гүний мэргэжлийн хяналтын байгууллагууд, түүний байцаагч нарын гол мөрдлөг болгодог хууль эрхзүйн баримт юм.
Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль	Стандартчилал, чанарын баталгаажуулалт, стандарт, чанарын хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах	Энэ хуулийн заалтуудад стандартыг боловсруулах, мөрдүүлэх, баталгаажуулах, хянах ажлыг бүхэлд нь стандарт хариуцсан төрийн төв байгууллага дангаар хариуцан гүйцэтгэх чиг үүрэгтэй байхаар заагдсан байна.
Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль	Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах	Тус хуулиар импортын бүтээгдэхүүний стандарт тохирлын үнэлгээг боловсруулах, мөрдүүлэх ажлыг стандарт хариуцсан төрийн төв байгууллага хэрэгжүүлэх ба хяналтыг улсын мэргэжлийн хяналт газар гүйцэтгэхээр заагджээ.
Хувиргасан амьд организмын тухай хууль	Хувиргасан амьд организмыг (шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн) гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэрт биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах	Байгаль орчны асуудал хариуцсан сайдын байгуулсан Биоаюулгүйн үндэсний зөвлөл хувиргасан амьд организм буюу шилжмэл гентэй хүнсний импортын зөвшөөрлийг зохих эрсдлийн үнэлгээний үндсэн дээр олгож байхаар хийгдсэн.
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	Бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах	Энэхүү хуулийн бүлэг заалт бүр хүнсний баталгаат байдлыг хангахад хэрэглэгч, үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын эрх үүргийг тодорхой зааж өгсөн.

Эдгээр хууль эрх зүйн актууд нь хүнсний аюулгүй байдлыг хангах эрхзүйн үндсэн баримт болох боловч хоорондоо уялдаа холбоо сул, хүнсний аюулгүй байдлын зарим чухал асуудал, заалтууд тодорхойгүй орхигдсон байна. Тухайлбал: **“Хүнсний тухай хууль”**-д

- “Хүнсний аюулгүй байдал гэж хүнсэнд чанар, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээ хангагдсан байхыг хэлнэ” гэж хангамж, хүртээмжийн асуудлыг орхиж, хүнсний бодлогын цогц байдлыг алдагдуулжээ.
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтууд, ялангуяа генийн инженерчлэл, биотехнологийн дэвшлийг ашиглан шинээр гаргаж авч байгаа шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтүүд, биологийн идэвхит нэмэлт хүнс, экологийн цэвэр бүтээгдэхүүн зэрэг зарчмын ойлголт, GMP, HACCP зэрэг орчин үеийн чанарын тогтолцоонуудын талаар заалт огт тусгагдаагүй байна.
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад хяналт тавьж оролцох төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ХХААЯ, ЭМЯ-ны үүрэг тодорхойгүй, дутуу, дулимаг болсон байна. Эрүүл ахуй, чанарын аюулгүй байдлыг хангах асуудлыг аль ч байгууллагад хариуцуулалгүй эзэнгүйдүүлж, үйлдвэр худалдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, СХҮТ-ийг чиг үүрэг, оролцоог тодорхойлоогүй орхижээ.
- “Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих улсын хяналтын тогтолцоо” гэсэн 12-р бүлэгт хүнсний аюулгүй байдлыг сонирхогч талуудын оролцоонд тулгууласан бодлогын тогтолцоо бус “аппаратжсан” төрийн бүтэц үүсгэх замаар хянах, шалгах, торгох шийтгэх бодлогыг барьсан хяналт бүрдүүлэхээр заагджээ.
- Хүнсний бүтээгдэхүүнд тавих чанарын шаардлага, шошгожуулалтын талаар дурьдагдаагүй байна.

**“Амьтан, ургамлын хорио цээрийн хяналт шалгалтын тухайн хууль”**-иар импортоор оруулж буй хүнсний бүтээгдэхүүнийг хянах шалгах асуудлыг зохицуулдаг бөгөөд манай улсын хилийн мэргэжлийн хяналтын албад баримтлан ажилладаг гол хууль эрх зүйн акт юм. Гэтэл энэ хуулинд хувь хүн, иргэд хүнсний бүтээгдэхүүн оруулж ирэхэд дээд тоо хэмжээний хязгаарыг тодорхой заагаагүй учраас хүнсний **ганзагын наймааг хязгаарлах хууль эрхзүйн үндэсгүй** болж байна. Гэтэл

бусад оронд хувь хүн зөвхөн хувийн хэрэгцээндээ<sup>19</sup> зориулах хүнсний бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх дээд хэмжээг хуулиар зааж өгсөн байдаг.

Бидний анхаарлыг хамгийн ихээр татаж байгаа асуудал бол дээрх 2 хуулиар мэргэжлийн болон хилийн хяналтын нүсэр, “мэргэжлийн бус” аппаратыг бий болгож, сонирхогч талуудын оролцоог огт хангаагүйгээс хүнсний чанарт хяналт тавих асуудлыг зөвхөн “аппаратын” хүчин чадлаар хийх ёстой асуудал болгож тавьснаар бодлогыг тогтоох боломжгүй, цаашилбал чанарын баталгаат байдлыг хангах бололцоогүй болгожээ. Өөрөөр хэлбэл, манай хуулиудад тухайн төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулах олон талын оролцоог анхаардаггүй, зөвхөн холбогдох төрийн төв байгууллагуудын чиг үүрэг, хэрэгжүүлэх төрийн салбар бүтцийг зааж өгөхөөр хязгаарладаг нь учир дутагдалтай байна.

Гэтэл 2007 онд батлагдсан “Хувиргасан амьд организмын тухай” хуулиар дэлхий дахинаа улам бүр өсөн нэмэгдэж буй шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүнийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зохих биоаюулгүй байдлын үнэлгээ гарсаны үндсэн дээр зөвшөөрөл олгон улсын хилээр нэвтрүүлэхээр заагджээ. Энэ нь урьдчилсан хяналтын тогтолцооны нэг элемент мөн бөгөөд учир нь хүнсний бүтээгдэхүүнийг хилээр оруулж ирэхээсээ өмнө тодорхой хэмжээний хяналт, шинжилгээнд хамруулах зарчим хэрэгжиж байгаагийн жишээ юм. Ийм шаардлага тавих нь зүйтэй бөгөөд ард иргэдээ био-аюулаас хамгаалах эхний алхмууд хийгдэж байна хэмээн сайшааж байгаа ч манайд одоогийн байдлаар хүнсний бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах асуудлыг дагнан хариуцсан тодорхой бүтэц, байгууллага байхгүй учраас (FDA шиг) зөвшөөрөл олгох процесс улам хүндрэл бэрхшээлтэй, чирэгдэл хүнд сурталтай болох вий гэсэн болгоомжлол төрж байна. Хүнсний хэрэгцээний дийлэнхи хувийг импортоор хангаж байгаа манайх шиг улс хүнсний импортод чанд хяналт тавьж иргэдээ хүнсний гаралтай элдэв эрсдлээс хамгаалахын зэрэгцээ мөн хүнс импортлох үйл явцыг чирэгдэл багатай, аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг татахуйц байдлаар зохион байгуулахгүй бол хүнсний хомсдол нүүрлэх аюултай.

<sup>19</sup> АНУ болон Европын холбооны улсуудын Хүнсний тухай хуулиудад нэг хүн хилээр авч явах хүнсний дээд хэмжээг 20 кг-аар хязгаарладаг.

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Ариун цэврийн тухай хуулиудад импортын хүнсний бүтээгдэхүүний стандарт тогтоох, тохирлын баталгаа олгох, ариун цэвэр эрүүл ахуйн хяналтыг УМХГ, хил гүний мэргэжлийн хяналтын байгууллагууд хэрэгжүүлэхээр заасан боловч тогтоосон стандартын дагуу шинжилгээ үнэлгээ гаргах лаборатори байхгүй (техникийн хүчин чадал сул, хүний нөөц хангалтгүй) нөхцөлд тунхаглалын шинжтэй хууль батлаад хэрэгжилт хангагдахгүйд хүрч байна. Тиймээс бодит нөхцөл, хүчин чадалдаа нийцсэн бодлого барих шаардлагатай байгаа бөгөөд анхнаасаа хэрэгжихгүй нь тодорхой хууль баталснаар аливаа хуулийг хэрэгжүүлэхгүй байж болох хандлага, нийгмийн сэтгэлгээг даамжруулах муу талтай.

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 11-д Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын захиалга, гэрээний дагуу төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалт явуулах, улсын стандартыг хэвлэн борлуулах гэж заасан нь СХҮТ-ийг төрийн үйлчилгээг үзүүлэх нэгж бус ашгийн төлөө ажиллахыг дэмжсэн утгатай заалт байна. Улмаар СХҮТ нь стандартуудыг таниулан сурталчлах боломжгүй, харин зарж борлуулах үүрэг хүлээсэн байгууллага болсон байна.

## **2.2. Хилийн бүртгэл, хяналтанд тулгуурласан тогтолцоо**

Импортын хүнсний чанарын баталгааг хангах, хянахад Монгол улс хил, гүний мэргэжлийн хяналтанд төвлөрсөн буюу хилээр нэгэнт орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг хянах шалгах тогтолцоо үйлчилж байна. Энэ нь хяналт бүрэн хийх бололцоогүй эсвэл хүнд суртал, хээл хахуулийг дэмжсэн, стандартын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн оруулах бололцоотой, улмаар олон улсын худалдааг хөнгөвчлөх зарчимтай зөрчилдсөн шийдэл болж байна. Үүнийг тайлбарлая. Энэхүү бодлогын судалгааны хүрээнд хийсэн хээрийн судалгаагаар хилийн боомтууд дээр очиж ажиглалт хийх явцад хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр буюу хилээр нэгэнт орж ирсэн машинууд олноороо дугаарлан зогссон байснаас хүнсний бүтээгдэхүүн ачсан нь олон байлаа. Үүний дотор хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай ачсан, бороо шорооны хамгаалалт муутай машинууд дийлэнх нь байсан юм (Зураг 2).

**Зураг 2. Замын-үүд дэх хилийн шалган нэвтрүүлэх цэг**

Хүнсний бүтээгдэхүүн хилээр оруулж ирж байгаа иргэдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд Хятадын тал руу явахдаа арьс шир, төмөр гэх мэт зүйл ачаад гарсан тээврийн хэрэгсэл эргэж Монгол улс руу орж ирэхдээ хүнсний бүтээгдэхүүн, ногоо зэрэг зүйл ачиж ирдэг байна. Хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэн оруулж ирж байгаа эдгээр тээврийн хэрэгсэлүүд нь наад захын хүнсний эрүүл ахуйн шаардлага хангахгүй, өмнө нь ачсан зүйлсээс (арьс шир зэрэг) үүдэлтэй бохирдолтой байх магадлалтай. Товч дүгнэхэд дээрхи маягаар хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих стандарт шаардлага хангагдахгүй байх бүрэн үндэслэлтэй болжээ.

Хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр ажиллаж байгаа хяналтын албаны хүмүүстэй хийсэн ярилцлага, ажиглалтаас харахад нэг машиныг шалгахад дунджаар 5-10 минут оногдож байгаа нь тээврийн хэрэгсэл бүрийг нарийвчлан шалгаж, стандартын биелэлтийг тогтоох хүн хүч, техникийн нөхцөл бүрдээгүй байна. Гэтэл хилийн мэргэжлийн хяналт, гаалийн албад тус тусдаа (Замын-үүд) хүнсний шинжилгээний лабораториудтай, давхардсан үйл ажиллагаа явуулж байгаа нь эдийн засгийн хувьд үрэлгэн төдийгүй бодлого уялдаа холбоогүй байгааг харуулж байна.

Хилийн хяналтын цэг дээр ажлын ачаалал өндөр, хяналтыг бүрэн хийх боломжгүйн дээр ил зөрчил (ямар ч хамаагүй машинд ачиж оруулж ирдэг зэрэг) их байгаа зэрэг нь хээл хахууль өгөх, авах нөхцөл болж байгаа тухай дээрх ярилцлагад орсон хүмүүс ярьж байсан.

Гэхдээ энэ нь нэгэнт хилээр ороод ирчихсэн зүйлсийг бүгдийг нэвтрүүлээд байдаг гэсэн үг биш. Хил, гаалийн хяналтын болон гүний мэргэжлийн хяналтын байцаагчид хүлээсэн үүргийн дагуу зөрчилтэй, бичиг баримтын бүрдэл дутуу бараа, материал, үүний дотор хүнсний барааг нэвтрүүлэхгүй байх, бүр устгах явдал гардаг. Энэ нь хилийн цэг дээрх хяналтын байцаагчид хүлээсэн үүргийнхээ дагуу ажил үүргээ гүйцэтгэж байгаагийн жишээ мөн боловч чанарын баталгаагүй хүнсний бүтээгдэхүүнийг борлуулсан “экспортлогч” тал нь хариуцлага хүлээхгүй, харин тэр бүтээгдэхүүнийг худалдан аваад хилээр оруулж ирсэн монголын иргэндангаараа хариуцлага хүлээн, хохирч байгаагийн жишээ болно.

Судалгааны хүрээнд бүрдүүлсэн анхдагч мэдээллээс дүгнэхэд манай улсад хилийг цэг дээр нэгэнт хил нэвтрээд ороод ирчихсэн хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаат байдалд хяналт тавьж байгаа нь тийм ч оновчтой тогтолцоо биш бололтой. Дэлхийн бусад улс оронд хилийн бүртгэл, хяналтын тогтолцооны гол зорилго нь бичиг баримтын бүрдэл, үнэн зөв байдлыг хянах зорилготой бөгөөд шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүнээс дээж авч сорьц, шинжилгээ хийдэг байна. Гэтэл одоо манай улсад хилийн цэг дээр баримт бичгийн хяналтын зэрэгцээ импортын хүнсний чанарыг хангах, хяналт тогтоох гол үүргийг хил, гаалийн хяналтынхан “нугалж” байна. Хүнсний бүтээгдэхүүний импортод ганзагын наймаа голлосон, гарал үүсэл тодорхойгүй, нэгэнт орж ирсэн бүтээгдэхүүний импортын стандартын зөрчил илэрвэл торгож шийтгээд л нэвтрүүлдэг одоогийн энэ байдал нь баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн “нийлүүлсэний” гол хариуцлагыг УМХГ, ХМХА хүлээхээр гаж гэмээр тогтолцоо бүрэлдээд байгааг харуулж байна. Гэтэл хилийн цэг дээрх ажлын ачаалал хэтэрсэн, лабораторийн хүчин чадал нэн доогуур байгаа, тээвэрлэлт хадгалалтын стандартыг ягштал баримтлах нөхцөл бүрдээгүйн дээр чанарын хяналт, түүний төлөөх хариуцлагыг манай импортлогч тал дангаараа хүлээж байгаа нь учир дутагдалтай.

### **2.3. Импортын хүнсний урьдчилсан хяналтын тогтолцоо**

Өнөөдөр дэлхийн улс орнууд урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцоогоор дамжуулан хүнсний бүтээгдэхүүнийг импортолж байна. Энэ нь импортлогч болон экспортлогч талууд урьдчилан

тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулж, импортлогч улсын стандарт, чанарын шаардлагыг хангасан баталгаат хүнсний бүтээгдэхүүнийг оруулж, хэрэглэгчдэд хүргэхийг хэлнэ. Үүнийг гол үе шатуудаар нь ялгаж харах юм бол:

- Эхлээд импортлогч болон экспортлогч талын мэргэжлийн байгууллагууд импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих стандарт, чанарын шаардлагуудаа тохирно.
- дараа нь уг мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас дотоодын аж ахуйн нэгжүүддээ мэдээлсний үндсэн дээр импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүд зах зээлийн зарчмаараа ажиллан хүнсний бүтээгдэхүүний импортын үйл ажиллагаагаа төлөвлөн, түншүүдтэйгээ гэрээ хэлэлцээр байгуулна.
- Гэрээ хэлэлцээрийн дагуу экспортлогч болон импортлогч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ шинжилгээнд өгч, тохирлыг гэрчилгээгээ авах ба үүнтэй нэгэн зэрэг бусад шаардагдах импорт, экспортын баримт бичгийн бүрдлээ гүйцэтгэнэ.
- Тохирлын, гарал үүслийн зэрэг гэрчилгээнүүд, гаалийн бичиг баримтын бүрдлийг нэгэнт хийж дууссан аж ахуйн нэгж хүнсний бүтээгдэхүүнээ хилээр оруулж ирэх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр зөвхөн баримтын шалгалт хийх ба үүнийг электрон хилийн хяналтын зарчмаар гүйцэтгэх нь олон улсад хэрэглэгддэг үр дүнтэй арга хэлбэр болно. Зөвхөн шаардлагатай тохиолдолд хилийн цэг дээрх хяналтын лабораторийн ажилтнууд бүтээгдэхүүний дээжийн шинжилгээ хийнэ.
- Хилийн хяналт, гаалийн баримтын шалтгалтаар зөрчилгүй гарсан хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэх, эцсийн хэрэглэгчид хүрэх шат дамжлага бүрт хяналт тавих боломжтой.
- Дэлгүүр, зах дээр зарагдаж байгаа бүтээгдэхүүний шошгожилт, хадгалалтын стандартын дагуу иргэд, хэрэглэгчид, олон нийтэд хяналт тавих бололцоо олгогдох ба зөрчил илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдээлэл өгч, хяналтын байцаагч шалгалт хийх нөхцөл бүрдэнэ.

Гадаад импортлогч тал нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ чанарын баталгаажуулах хариуцлага хүлээх, харин дотоод импортлогч тал нь оруулж ирснийхээ дараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтыг

баталгаажуулснаар хүнсний бүтээгдэхүүнийг импортлох үйл явцын шат алхам болгон нь хариуцах эзэнтэй болдог. Иймд урьдчилсан хяналт нь дараа дараагийн болзошгүй эрсдлээс сэргийлэх, хүнсний чанарын баталгааг хангах дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн үр дүнтэй хяналтын тогтолцооны арга зам болсон.

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 16.7-д заасны дагуу холбогдох орны эрх бүхий байгууллага нь тухайн бүтээгдэхүүнд олгосон тохирлын гэрчилгээг хүлээн зөвшөөрч баталгаажуулдаг. Гэвч тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх талаар манай улс ОХУ, Украин, БНХАУ гэсэн гуравхан улстай гэрээтэй боловч эдгээр улсуудаас ч тохирлын үнэлгээгүй хүнсний бүтээгдэхүүн гол төлөв ганзагыг наймаагаар дамжин орж ирсээр байна. Манай улсын жижиг аж ахуйн нэгжүүд, ганзагын наймаа эрхлэгч хувь иргэд чанарын баталгаагүй, гарал үүсэл тодорхойгүй, хүнсний бүтээгдэхүүн импортлоход одоогийн хилийн мэргэжлийн хяналтанд тулгуурласан системээр хянаж бараа хураагдах, бүр устгагдахад хүрэхэд нийлүүлэгч талын хариуцлага үгүй тул зөвхөн манай иргэд, компаниуд хохирч байна. Дэлхийн бусад улс орнуудад урьдчилсан хяналт тогтоож импортын хүнсний чанарыг баталгаажуулахад үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч талд хүнсний үйлдвэрлэлийн тогтолцооны болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дараах шаардлагуудыг тавьдаг болжээ. Үүнд:

- *НАССР тогтолцоо, GMP, GAP үйлдвэрлэлийн шаардлага*

НАССР нь үйлдвэрлэлийн эгзэгтэй бохирдож болох үе шат, цэгүүдэд эрүүл ахуйн, чанарын хяналтыг нэвтрүүлж эцсийн бүтээгдэхүүн эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан байх тогтолцоог бүрдүүлэхийг хэлнэ.

GMP, GAP гэдэг нь үйлдвэрлэлийн орчин, удирдлага, менежментийг шилдэг туршлага нэвтрүүлсэн, үйлдвэрлэлд хэрэглэгдэх түүхий эд, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, техник технологи нь орчин үеийн өндөр шаардлага хангасан үйлдвэрлэлийн хэм хэмжээг ойлгодог.

- *Импортын хүнсний стандартчилал, тохирлын үнэлгээ олгох*

Экспортлогч тал импортлогч улсын хүнсний зохих стандартын үзүүлэлт, шаардлагыг хангасан байх ёстой. Жишээлбэл тухайн үйлдвэрлэгч чанарын удирдлагын ISO9001, ISO14001 стандартуудын шаардлага хангаж байвал олон улсын хэмжээнд чанарын шаардлага



хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэсэн баталгаа болж өгдөг. Хэрвээ импортын бүтээгдэхүүн импортлогч талын эсвэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн шинжилгээний дагуу стандартын шаардлагыг хангаж байвал зохих тохирлын баталгааг олгодог.

▪ *Импортын хүнсний бүтээгдэхүүний шошгожуулалт*

Импортын хүнсний урьдчилсан хяналтын үед тухайн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн хугацаа, найрлага, код, хадгалах хугацаа, хадгалах, тээвэрлэх нөхцөл, нууцлалын талаарх мэдээлэл агуулсан шошгожуулалтын загварыг хоёр тал тохирч, хилийн хяналтад мэдээлэх явдал юм.

Урьдчилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь импортын хүнсний бүтээгдэхүүний хяналт бүртгэл сайжирч, тээвэрлэлт хадгалалтын нөхцлөөс шалтгаалсан хүнсний бохирдол, муудалтыг ялган тогтоох боломжтой болж, улмаар ганзагын наймааг хязгаарлах, чөлөөт худалдааг хөнгөвчлөх, хариуцлагыг гадаад, дотоод нийлүүлэгч талуудад бий болгоно.

### 3. УРЬДЧИЛСАН ХЯНАЛТАНД ТУЛГУУРЛАСАН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМУУД


#### 3.1. Хилийн болон урьдчилсан хяналтанд тулгуурласан хяналтын тогтолцооны хувилбаруудын харьцуулалт

Монгол улсад одоо үйлчилж буй хилийн мэргэжлийн хяналтын тогтолцоог урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцоотой дараахи шалгуур үзүүлэлтүүдээр харьцуулан жишив.

**Зардлын үр ашиг (Cost efficiency):** Хилийн хяналтын тогтолцоо нь хүн хүч, лабораторийн техникийн өндөр хүчин чадлыг шаарддаг тул хяналт шалгалтын өртөг зардал үүний хэрээр нэмэгддэг. Тэгвэл урьдчилсан хяналтын тогтолцооны үед хилийн хяналтын гол зорилго нь тохирлын гэрчилгээг шалгах, бичиг баримтын үзлэгийг хийх байдаг тул хилийн хяналт шалгалтын зардал буурна. Импортлогчид, тээвэрлэгчдийн хувьд одоогийн тогтолцоо нь нэгэнт орж ирсэн бүтээгдэхүүнийг хянаж шалгахад чиглэсэн тул тэднээс гарах зардлыг нэмэгдүүлж улмаар хээл хахуулийг өөгшүүлэх, далд эдийн засгийг үүсгэх боломжтой. Мөн хүнсний чанарын баталгаат байдлыг хангахын тулд хилийн боомт бүрт өндөр түвшний лабораториуд байгуулах шаардлагатай бол урьдчилсан хяналтын тогтолцоонд урьдчилан шинжлэх, бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны тусламж авах, хөрш улсуудтай стандартыг тохирох замаар хүнсийг сорьж баталгаажуулах зардлыг хэмнэх бололцоог олгоно.

**Нийгэмд үзүүлэх нөлөө (Activity effectiveness):** Хилийн хяналтын тогтолцоо нь олон улсын худалдааг хөнгөвчлөх нийтлэг чиг хандлагаас хазайж, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээнд итгэх итгэлийг сулруулж, хүнд сурталыг бий болгож байгаа бол урьдчилсан хяналтын тогтолцоо нь чөлөөт худалдааг хөнгөвчилж, хүнсний бүтээгдэхүүний бүртгэл, чанарын хяналтыг үйлдвэрлэгч нийлүүлэгчээс эхлэн хэрэглэгч хүртэл тогтоох бололцоог олгож байдаг давуу талтай. Хилийн хяналтын тогтолцоогоор хянахад нэгэнт орж ирсэн чанаргүй бараа хураагдах,

бүр устгагдахад хүрэхэд зөвхөн манай иргэн, компаниуд хохирох эсвэл хээл хахуулийн замаар чанаргүй бүтээгдэхүүн орж ирэх боломжийг нээлттэй үлдээдэг. Харин урьдчилсан хяналтын тогтолцоо нь гадаад нийлүүлэгч талд давхар хариуцлага хүлээлгэх, баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгдэх эрсдлээс урьдчилан сэргийлэх бололцоог олгох төдийгүй шударга өрсөлдөөнийг дэмжиж, бизнесийн таатай орчинг бүрдүүлнэ. Урьдчилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлсэнээр одоо манайд тулгамдаад байгаа баталгаагүй хүнс нийлүүлдэг жижиглэн, ганзагын наймааг хязгаарлах боломжийг буй болгоно.



**Хэрэгжүүлэх боломжит байдал:** Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн үед хүнсний аюулгүй байдлын бодлого алдагдаж, хүнсний хангамжийн бодлогыг голлон анхаарсаар өнөөг хүргэжээ. Шилжилтийн үеийг даван туулж, ард түмний амьжиргаа сайжирч, эдийн засгийн өсөн нэмэгдэж буй өнөөгийн энэ үед хүнсний чанарын баталгаат байдлыг хангах урьдчилсан хяналтын тогтолцоог бий болгох олон нийтийн шаардлага, бодлого баригчид, шийдвэр гаргагчдын улс төрийн хүсэл зориг манайд оршин байна. Иймд урьдчилсан хяналтын тогтолцоонд бүрэн шилжихийн тулд холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах, шилжилтийн үе шат, цаг хугацаа, өртөг зардлыг нарийвчлан тооцох шаардлагатай.

### **3.2. Олон нийтийн хяналт, оролцооны механизмууд**

Зах зээлийн арвин туршлагатай орнуудад “хэрэглэгч та хаан” зарчим үйлчилдэг бөгөөд энэ нь үйлдвэрлэгч, нийлүүлэгчид хэрэглэгчийн өмнө хариуцлага хүлээх ёсзүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Манай улсын хувьд олон нийт, үйлдвэрлэгчид, импортлогчдын энэ талын харилцаа, ойлголт дутуу дулимаг байгааг сайжруулах, сургалт сурталчилгааг дэлгэрүүлэх, мэдлэг дадал олгох ажлыг эрчимжүүлэх учиртай. Монгол Улсын “Хүнсний тухай хууль”-ийн 16-р зүйлд “олон нийтийн оролцооны талаар иргэд, төрийн бус байгууллага нь холбогдох албан тушаалтанд мэдэгдэх, олон нийтийг сэрэмжлүүлнэ” гэж заажээ. Манай орны нөхцөлд олон нийтийн энэ талын мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, импортын хүнсний бүтээгдэхүүнийг хуулинд заасны дагуу монгол хэл дээр шошгожуулах шаардлагыг заавал дагаж мөрдүүлэх, зөвхөн шошгожуулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, худалдааны цэгээр зарж борлуулах зэрэг нь олон нийтийн түвшинд хяналт тогтоох боломжийг бүрдүүлж, хяналт шалгалтын зардлыг бууруулах, хүнсний чанарын аюулгүй байдлыг баталгаажуулах боломжийг олгоно.

ТББ-ын тухай хуулийн 9-р зүйлийн 5-д Төрийн байгууллагын холбогдох зарим эрх үүргийг ТББ-д шилжүүлж болно гэж заасны дагуу хүнсний аюулгүй байдлын талаар олон нийтэд сургалт сурталчилгаа явуулах, нээлттэй мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлыг Монголын Хүнсчдийн Холбоо, ХЭАХН зэрэг холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж, үйл ажиллагааг дэмжих нь олон нийт, сонирхогч талуудыг оролцуулах боломжийг олгосон илүү үр дүнтэй арга зам болдогийг олон улсын туршлагууд харуулж байна.

#### 4. ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын явцад цуглуулсан мэдээлэл, баримтуудад тулгуурлан дараахи дүгнэлтийг хийж байгаа болно. Үүнд:

- Судлаач, эрдэмтэд, олон улсын байгууллагын үнэлгээгээр Монгол Улсын хүнсний **хангамж гадаад улсаас хараат** байгаа бөгөөд **чанарын баталгаат байдал алдагдсан** байна. Сүүлийн жилүүдэд импортын хүнсний бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлт эрс нэмэгдсэн хэдий ч нийлүүлж буй хүнсний чанар, эрүүлахуйн байдалд дорвитой өөрчлөлт гараагүй, бүр дордсоныг хүнсний гаралтай өвчлөлтүүд, эрүүл мэндийн үзүүлэлтүүд харуулж байна. Импортын хүнсний чанар, аюулгүй байдалтай холбогдох нарийвчилсан судалгааны ажил дутагдалтай байгаа нь үнэн боловч хүнсний гаралтай хүн амын өвчний тоо нэмэгдэж байгаагаас **хүнсний аюулгүй байдал нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрсэн** гэж үзэхээр байна. Үүнээс гадна өнөөгийн нөхцөлд тогтоож чадахгүй байгаа хүн амын удмын санд үзүүлэх хэтийн сөрөг нөлөөг бодолцох хэрэгтэй болжээ. Манай улсын импортын хүнсний гол нийлүүлэгч болох БНХАУ нь мөн хүнсний дутагдалтай улсад хамаардаг бөгөөд дэлхий нийтийн санааг зовоосон хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах химийн хортой бодис, хүнд металлын бохирдол зэрэг хүнсний чанарын баталгаат байдлаар эрсдэлтэй орны тоонд ордог. Иймд манай улс ойрын ирээдүйд жижиг, дунд хувийн хэвшлийг дэмжих замаар эх орны экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хүн амаа хангах цогц бодлого явуулах хэрэгтэй байгаатай судлаачид санал нийлж байна. Харин хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах гол хандлага нь дотоодын хүнс, ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал гэж олон хүн үздэг боловч хүнснийхээ 70%-ийг гаднаас авч буй хараат байдлыг бид 2-3 жилд огцом бууруулах бодит боломж үгүй бөгөөд цаашид ч хүнсний хангамжийн тодорхой хувийг бодитойгоор эзэлсээр

байх импортын хүнсний чанарыг баталгаажуулах, хянах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болжээ.

- Хүнсний хангамж, чанарын аюулгүй байдалтай холбоотой Монгол Улсын хууль эрх зүйн актууд нь орчин үеийн шаардлага хэрэгцээг хангахгүй, уялдаа холбоо муутай байна гэж үзэж байна. Тухайлбал Хүнсний тухай хуульд дэлхийн зах зээлд улам бүр нэвтэрч буй шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн, биологийн идэвхит нэмэлтүүд, экологийн цэвэр бүтээгдэхүүн зэрэг чухал ойлголтуудыг томъёолон оруулаагүй байна.

Мөн хүнсний эрүүл ахуй, чанарын баталгаат байдлыг бодлогоор хангах хэрэгжүүлэх төвлөрсөн бүтэц Монгол улсын хуулиудад заагдаагүй учраас ХХААЯ дотоодын ХАА салбар луу голлон анхаарсан байдалтай, ЭМЯ хүнсний талаар зөвлөмж, үнэлгээ гаргах төдий ажилтай, УМХГ, ХМХА-д зөвхөн хянах шалгах үүрэгтэй болсон нь хүнсний аюулгүй байдлыг бодлогын хувьд эзэнгүйдүүлж, хүнс нь баталгаажсан орчин үеийн дэлхийн бусад орнуудад зарчим болгосон хүний эрүүл мэнд рүүгээ чиглэсэн хүнсний аюулгүй байдлын бодлогоос эрс хазайсан хууль эрхзүйн актууд үйлчилж байгааг өөрчлөх цаг болжээ.

- Импортын хүнсний хяналтын хувьд нэгэнт орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавих хил, гаалийн хяналтын тогтолцоо үйлчилж байна. Ийм тогтолцоо нь Монгол Улсад импортоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг хангаж чадахгүй нь олон жилийн туршид батлагдлаа.

Нөгөөтэйгүүр одоогийн мэргэжлийн хяналтын тогтолцоо нь “мэргэжлийн бус” шинжтэй, нэлээн аппаратжсан тогтолцоо бөгөөд хянах, торгох төдий үүрэгтэй, мөн гаалийн хяналт, хилийн мэргэжлийн хяналтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд нь уялдаа холбоо муутай байна. Жишээлбэл, Хилийн мэргэжлийн алба, гаалийн алба нь тус тусдаа хүнсний шинжилгээний лабораторитай байгаа нь улсын төсвийг үргүй зарсан, давхардсан үйл ажиллагаа явуулдагийн нотолгоо юм.

- Хүнсний бүтээгдэхүүнийг гадаад нийлүүлэгч буюу үйлдвэрлэгч эсвэл экспортлогч улсын эрх бүхий байгууллагатай урьдчилан тохирч гэрээ байгуулсаны үндсэн дээр оруулж ирдэг урьдчилсан

хяналтын тогтолцоонд шилжих шаардлагатай болжээ. Харин одоогийн хилийн мэргэжлийн хяналт нь бичиг баримтын хяналт, шалгалт хийх гол үүрэгтэй атлаа хянах, шалгах, торгох замаар хүнсний аюулгүй байдлыг “хангаж” байгаа нь хүнсний чанарын баталгаат байдлыг хангах бололцоогүй тогтолцоо төдийгүй чөлөөт худалдааг хязгаарлаж байна. Үүнтэй уялдуулан урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцооны чухал элемент болох стандартуудыг боловсруулах явцыг улам сайжруулах шаардлагатай болжээ. Үүнд хөрш зэргэлдээ улсууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол улсад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг улс орнуудтай ижил стандарт хэрэглэх, бүтээгдэхүүний тохирлын гэрээн дээр үндэслэн хүнсний бүтээгдэхүүнийг оруулдаг болох нь хилийн хяналтын ачааллыг бууруулж, чөлөөт худалдааг нэмэгдүүлэх сайн талтай. Стандартыг хянаж тогтоох мэргэжлийн нарийн лабораториудыг байгуулах нь буурай хөгжилтэй манай орны хувьд техник, хүний нөөцийн хувьд хүндрэлтэй буюу хязгаарлагдмал тул бүс нутгийн болон олон улсын нэр хүндтэй лабораториудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой.

- Монгол улсад нийлүүлэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүний нэлээд хувь нь жижиг аж ахуйн нэгж, ганзагын наймаа эрхлэгчдэд оногдож байгаа нь хүнсний чанарын аюулгүй байдлыг улам дордуулж байна. Хувь хүний хилээр оруулах хүнсний бүтээгдэхүүний дээд тоо хэмжээг холбогдох хууль журманд тодорхой зааж өгөөгүйгээс (Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд оруулах) ганзагын наймааг хязгаарлах, цаашид таслан зогсоох хууль эрхзүйн үндэсгүй болж байна. Импортын хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлдэг томоохон аж ахуйн нэгжүүдийг хүнсний аюулгүй байдлыг хангасан хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэнтэй нь уялдуулан татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас олгох зэрэг эдийн засгийн аргаар хөхиүлэн дэмжих төрийн бодлого бас үгүйлэгдэж байна.
- Манай улсад сав, баглаа, боодол муутай импортын хүнсний бүтээгдэхүүнийг нэн хангалтгүй нөхцөлд тээвэрлэн, хадгалах нь элбэг бөгөөд тавих хяналт сул байгаа нь муудсан болон хугацаа дууссан бүтээгдэхүүнийг зарж борлуулах нөхцлийг олгож байна.

- Монгол Улсын хууль журманд заасан импортын бүтээгдэхүүн, түүний дотор хүнсний бүтээгдэхүүнийг монгол хэл дээр шошгожуулах шаардлага төдийлөн хэрэгжихгүй байна. Шошгожуулалт нь тухайн хүнсний бүтээгдэхүүний тухай мэдээллийг агуулахаас гадна хэрэглэгчдийн түвшинд хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа, горим зэргийг хянах бололцоог олгодог. Иймд эх хэл дээрхи шошгожуулалтыг заавал мөрдүүлж, олон нийт, үйлдвэрлэгчид, импортлогчдын хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлагын талаархи мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх нь хүнсний чанарын баталгаажуулалтыг дээшлүүлэх чухал хүчин зүйл болно.

Эцэст нь Монгол улсад хүнсний чанарын аюулгүй байдлыг тогтоох, үнэлгээ гаргах зэрэг нарийвчилсан судалгааны ажлууд үгүйлэгдэж байгааг давтан онцлоё.



## 5. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад хүнсний чанарыг баталгаажуулах урьдчилсан хяналтын тогтолцоог бий болгохтой холбоотойгоор дараахи санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

### **Холбогдох хууль эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах талаар**

- Олон улсын жишгийн дагуу импортын хүнсний хяналтын асуудлыг тусгайлан хариуцсан ЭМЯ-ны дэргэд байх Хүнс, эмийн хяналтын нэгдсэн албыг байгуулж, хуульчлан, Монгол Улсын Хүнсний тухай, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай, Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиудад зохих өөрчлөлтийг тусгах;
- Хуулиудад ялангуяа шинээр боловсруулж буй Хүнсний тухай хуулинд хүнсний эрүүл ахуй, чанарын аюулгүй байдлыг хангахад чухал оролцоотой ЭМЯ-ны чиг үүргийг тодорхой зааж, Монгол Улсын Эрүүл ахуйн Ерөнхий эмчийг Эрүүл мэнд хариуцсан сайд байхаар хуульчлан оруулах;
- Шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн, биологийн идэвхит нэмэлт хүнс, экологийн цэвэр бүтээгдэхүүн, баяжуулсан хүнс, HAC-CP, GMP, GAP тогтолцоо зэрэг орчин үеийн хүнсний үйлдвэрлэлтэй холбогдох чухал ойлголтуудыг хуулиудад томъёолон оруулах;
- Хүнсний тухай хуулинд хүнсний аюулгүй байдал, баталгаат байдлыг хангах, эрсдлийг үнэлэх<sup>20</sup> гэсэн тусгай бүлгүүдийг нэмж оруулах, Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, тогтолцоо гэсэн 4-р бүлэг болон гадаад худалдааны харилцааг зохицуулж байгаа хууль, журмуудад хүнсний импортын урьдчилсан хяналтын тогтолцоо болон түүнтэй холбогдох заалтуудыг нэмж оруулах;

<sup>20</sup> Европын Холбооны Хүнсний тухай хуулинд дээрхи бүлгүүдийг тусгайлан оруулсан байна.

- Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулинд хувь хүний хилээр оруулж болох хүнсний бүтээгдэхүүний дээд хэмжээг тогтоож хуульчлан заах;
- Хүнсний эрүүл ахуй, чанарын аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдэд зохих шалгуурын дагуу татварын тодорхой хөнгөлөлт, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хуулиудад (Гаалийн тарифийн тухай хууль) тусгах;
- Холбогдох хуулиудад хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцох мэргэжлийн ТББ, судалгааны байгууллагуудын оролцоог тодотгон заах;
- Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай 18-р зүйлийн 11-д СХГ улсын стандартыг хэвлэн борлуулах гэсэн заалтыг хасч, олон улсын жишгийн дагуу стандартуудыг цахим сүлжээ, интернетийг ашиглан үйлдвэрлэгчдэд ойртуулах, олон нийтэд таниулах, түгээх үүднээс нээлттэй болгох;

#### **Төрийн бодлого, үйл ажиллагааг оновчтой болгох талаар**

- НЭМХ-д хүнсний аюулгүй байдлын стратеги, төлөвлөлт бодлогыг боловсруулах, сонирхогч талуудад хүргэх чиг үүргийн оногдуулан, шаардлагатай бүтцийн өөрчлөлтийг хийх;
- Импортлож буй хүнсийг хил дээр хянаж шалгадаг бус урьдчилан гэрээ хийсний үндсэн дээр импортлогч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч талуудад хариуцлага хүлээлгэдэг, урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцоог бий болгож, үүнд чиглэсэн бодлогыг хүнсний чанарын баталгааг хангах үндэс суурь болгох;
- Урьдчилсан хяналтын тогтолцооны нэг бүрэлдэхүүн болох электрон гаалийн болон мэргэжлийн хяналтын бичиг баримт бүрдүүлэлтийг бодлогын хувьд дэмжин буй болгох;
- Хөрш болон бусад манай улсад экспортлогч улсуудтай хүнсний бүтээгдэхүүний стандартыг харилцан тохирч, зөвхөн урьдчилан тохирсон бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр оруулах талаар гэрээ хэлцэл байгуулах;

- Урьдчилсан хяналтанд тулгуурласан тогтолцоо нь ганзагын наймааг хязгаарлах боловч төрөөс энэтөрлийн хүнсний сүлжээг хумих бодлогыг хэрэгжүүлж, үүний зэрэгцээ хариуцлага тооцож болох цөөн тооны монополь бус байх импортлогч томоохон аж ахуйн нэгжүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх бодлого явуулах;

### **Стандарт, шошгожуулалтыг мөрдүүлэх талаар**

- Хөрш болон хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч гол улс орнуудтай нэгдсэн стандартуудыг мөрдөх тохиролцоонд хүрэх;
- Техник, хүний хязгаарлагдмал нөөцтэй манай улсын хувьд хилийн боомт бүрт өндөр түвшиний лаборатори байгуулах нь эдийн засгийн хувьд хүндрэлтэй, мөн хүний нөөц техникийн талаас боломжгүй тул хүнсний бүтээгдэхүүнийг урьдчилан шинжлэх бие даасан, орчин үеийн лаборатори байгуулах, эсвэл зарим зардал бүхий шинжилгээг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд бусад улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх;
- Хуулинд заасны дагуу импортын хүнсний бүтээгдэхүүнийг зохих шаардлагын дагуу монгол хэл дээр шошгошжуулах явдлыг үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд тавьж, заавал дагаж мөрдүүлэх буюу зөвхөн шошгожуулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

### **Олон нийт, ТББ-уудын хяналт, оролцоог нэмэгдүүлэх талаар**

- ТББ-ын тухай хуулинд заасны дагуу олон нийт, сонирхогч талуудад мэдээлэл хүргэх, хүнсний аюулгүй байдлын талаархи сургалт сурталчилгааг явуулах үйл ажиллагаанд мэргэжлийн ТББ-дыг татан оролцуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллах;
- Олон нийт, ТББ-дын зүгээс хүнсний чанарын аюулгүй байдалд хяналт тавих оролцоог нэмэгдүүлэх урамшууллын механизмыг бүрдүүлэх;
- Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, журмуудад иргэд, сонирхогч талуудаас ирэх мэдээллийг хүлээж авах, мэдээллийг дагуу арга хэмжээ авч, олон нийтэд мэдээллийн хэрэгсэлээр болон мэдээлэл өгсөн этгээдэд албан захидал явуулах замаар мэдээллийн дагуу авсан арга хэмжээгээ мэдээлдэг тогтолцоог хуульчлах;

## 6. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

### Хавсралт 1. Хүнсний хангамж



### Зарим хүнсний бүтээгдэхүүний импортын байдал<sup>22</sup>

№	Нэр	1990	2002	2003	2004	2005
1.	Үр тариа /мян.тн/	-	139,2	61,5	114,9	97,5
2.	Гурил /мян.тн/	27,7	96,9	75,2	79,3	103,9
3.	Төмс, хүнсний ногоо /мян.тн/	-	41,4	30,4	32,4	28,1
4.	Цэцгийн тос /тн/	-	18,6	55,5	5,0	8,4

Манай улс хэрэгцээт гурилынхаа 70 %, төмс хүнсний ногооны 30-50%, гахай шувуу, өндөгний 70-80%, жимс жимсгэнэ, цэцгийн тосны бараг зуун хувийг импортоор оруулж ирж байна.

Гэтэл 1990-ээд онд гурил, төмс хүнсний ногоо, цэцгийн тосыг 100 хувь дотоодын ХАА салбар үйлдвэрлэж, зарим төрлийн бүтээгдэхүүнийг бүр экспортлох хэмжээнд байжээ.

<sup>21</sup> FAO - Low-Income Food-Deficit Countries, <http://www.fao.org/countryprofiles/lifdc.asp?lang=en>

<sup>22</sup> ҮСГ-ын мэдээнээс

**Хавсралт 2. Монгол улсын гадаад худалдааны байдал** <sup>23</sup>

Худалдааны нэр төрөл	2002 /сая \$/	2003 /сая \$/	2004 /сая \$/	2006 /сая \$/
Экспортын нийт бүтээгдэхүүний хэмжээ	524,0	615,9	869,7	1542,8
Экспортод мал амьтан, ургамлын гаралтай болон бэлэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хэмжээ	32,0 /6,1%/	23,9 /3,9%/	25 /2,9%/	36,8 /2,4%/
Импортын нийт бүтээгдэхүүний хэмжээ	690,7	801,7	1021,1	1485,6
Импортод мал амьтан, ургамлын гаралтай болон бэлэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хэмжээ	129,5 /18,7%/	115,6 /14,4%/	159,4 /15,6%/	180,0 /12,1%/
	2002	2003	2004	2006
Экспортын мэдүүлэг	20472	35501	62570	35293
Импортын мэдүүлэг	59007	64724	73412	96477

2007 оны эхний 9 сарын байдлаар 1299,6 сая ам. долларын бүтээгдэхүүн экспортоор гаргасан нь 2006 оны мөн үетэй харьцуулахад 219,4 сая. ам доллараар илүү байгаа бол импортоор 1462,1 сая ам. доллар бараа оруулсан 2006 оны мөн үетэй харьцуулахад 394,2 сая ам. доллараар их буюу 36,9 хувиар өсчээ. Үүний дотор мал амьтан, ургамлын гаралтай болон бэлэн импортын хүнсний бүтээгдэхүүн 166,5 сая ам. доллар буюу нийт импортын бүтээгдэхүүний 11,4%-ийг эзэлж байв.

<sup>23</sup> УГЕГ - Гадаад худалдааны гаалийн статистик мэдээ 2002-2007 9 сар

### Хавсралт 3. Импортын хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалтын зарим дүн

Монгол улс сүүлийн жилүүдэд жилд дунджаар 500 гаруй мянган тонн хүнсний бүтээгдэхүүн импортолсон ба УМХГ-ын хил гүний хяналтанд тэдгээрийн 40 гаруй хувь нь хамрагдсан ба үүний 7,8 хувь нь “шаардлага хангахгүй” гэсэн дүгнэлт гарчээ. Манай улсад олон улсын болон орон нутгийн чанартай 23 хилийн боомт, Улаанбаатар хотын гүний хяналтын 14 объектоор импортын хүнсний бүтээгдэхүүн нэвтэрч байгаа бөгөөд УМХГ-ын ХГХА-ны 150 гаруй байцаагч хяналт тавьдаг. 2003-2005 онд малын гаралтай 640, ургамлын гаралтай 2912 бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгосон бөгөөд 2005 онд гэхэд улсын хэмжээнд УМХГ, ХМХА-нд нийт 16500 гаруй аж ахуйн нэгжийг хүнсний эрүүл ахуйн хяналтанд хамруулжээ

2006 онд Улаанбаатар хотын хүнс борлуулагч аж ахуйн нэгжүүдэд ХХААЯ, ЭМЯ, НЭМХ-тэй хамтарсан хийсэн (нийт бүтээгдэхүүний 55,6% эх орны, 44,4% импортын гаралтай байв) хүнсний бүтээгдэхүүний түүвэр судалгаагаар нэлээд анхаарал татсан сөрөг үр дүнгүүд гарчээ<sup>24</sup>.

Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалт, тээвэрлэлт, эрүүл ахуйн нөхцөлийг авч үзвэл дараахи байдалтай байв.

Хүнсний бүтээгдэхүүнд гарсан зөрчил	Хувь хэмжээ
Агуулахгүй худалдааны нэгж байгууллага	44,5%
Бүтээгдэхүүний түргэн бохирдох эрсдэлт орчинтой	29,1%
Бүтээгдэхүүнийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр зөөвөрлөдөг	71,1%
Хадгалалтын хугацаа тавигдаагүй	69,7%
Нянгийн бохирдолтой	17,4%
Химийн шинжилгээний шаардлага хангахгүй	20,5
БНХАУ-д үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд илэрсэн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү гарсан хар тугалгатай бүтээгдэхүүний хэмжээ	38,6%


<sup>24</sup> ХХААЯ, НЭМХ Хүнсний бохирдлын судалгаа 2006

#### Хавсралт 4. Хүнсний гаралтай халдварт өвчний байдал

2006 онд улсын хэмжээнд 27 төрлийн цочмог халдварт өвчний 36221 тохиолдол гарсан нь өмнөх оныхоос 3389 тохиолдлоор (12.4 промилээр нэмэгдсэн), өмнөх таван жилийн дунджаас 3321 тохиолдлоор өндөр байна. Цусан суулга, хүнсний гаралтай бактерийн хордлого (176 тохиолдол буюу 10000 хүн амд 0,7), сальмонеллоз, балнад, суулгалт халдвар, вируст гепатит А зэрэг гэдэсний халдвар өвчний 7782 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 21,5 хувийг эзэлж байна<sup>25</sup>.

Үүний дотор вируст гепатит 323, цусан суулга 38, хүнсний гаралтай бактерийн хордлого 24, сальмонеллоз 13 тохиолдлоор тус тус нэмэгджээ.


Хүнсний гаралтай бактерийн хордлого илэрсэн байдал




<sup>25</sup> ЭМЯ, ЭМХҮТ-ээс гаргасан “Эрүүл мэндийн үзүүлэлт 2006” ТОВХИМОЛ

### Хавсралт 5. 6 сартайгаас 5 нас хүртэлхи хүүхдийн хоол тэжээлийн байдал<sup>26</sup>

(2004 оны байдлаар)



### Хавсралт 6. 15-49 насны жирэмсэн бус эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал




2004 онд эмэгтэйчүүдийн жингийн үзүүлэлтийг 1999 онтой харьцуулахад тураал 2 дахин буурсан бол илүүдэл жин 1,8 дахин ихэссэн дүнтэй гарсан. Төрөх насны эмэгтэйчүүдэд чухал амин дэмүүд (А, Д), төмөр, фолийн хүчлийн дутагдал өндөр байгаа нь судалгаагаар тогтоогджээ. .


<sup>26</sup> НЭМХ-гийн “Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал” судалгаанаас авав.



**Хавсралт 7. 15-49 насны эмэгтэйчүүдийн дундахи цус багадалт, Д витамин дутагдалын хувь хэмжээ**





**Хавсралт 8. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх таван шалтгаан (2001-2006)<sup>27</sup>**



<sup>27</sup> ЭМХҮТ-ийн 2006 оны тайлангаас авав.

### Хавсралт 9. Нас баралтын зонхилох шалтгаан хүйсээр (2006 он)<sup>28</sup>



1995 оноос хойш хүн амын нас баралтын шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, осол гэмтлийн шалтгаант нас баралт тогтмол эхний байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна.

2006 онд хүн амын нас баралтын шалтгааны 38.4 хувийг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 18.5 хувийг хавдар, 18.4 хувийг осол гэмтэл, хордлого ба гадны шалтгааны өвчлөл эзэлж байна. Өөрөөр хэлбэл жилд дунджаар 5500-6000 хүн буюу гурван хүний нэг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 2800-3000 хүн буюу таван хүний нэг нь хавдар, осол гэмтэл, хордлого ба гадны шалтгааны улмаас тус тус нас барж байна.


<sup>28</sup> ЭМХҮТ-ийн 2006 оны тайлангаас авав.

### Хавсралт 10. Хорт хавдрын нас баралтын байдал<sup>29</sup>


Хорт хавдрын өвчлөл нь сүүлийн 10 жилийн турш хүн амын нас баралтын 2 дах тэргүүлэх шалтгаан хэвээр байна.

2006 оны байдлаар хавдарын нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 12.49, 10000 эмэгтэй хүн амд 9.64 ногдож байна.

#### Эрэгтэйчүүдийн хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан, хувиар, 2006 он



#### Эмэгтэйчүүдийн хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан, хувиар, 2006 он



<sup>29</sup> ЭМХҮТ-ийн 2006 оны тайлангаас авав.

## 7. НОМЗҮЙ

### **Монгол Улсын болон олон улсын хууль эрхзүйн баримтууд**

1. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
2. Хүнсний тухай хууль (1999 он, шинэчилсэн)
3. Ариун цэврийн тухай хууль (1998 он)
4. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль (1994 он)
5. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль (2003 он)
6. Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль (2002 он)
7. Гаалийн тухай хууль (1996 он)
8. Гаалийн тарифийн тухай хууль (1996 он)
9. Хувиргасан амьд организмын тухай хууль (2007 он)
10. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003 он)
11. “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөр (2001 он)
12. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль (2000 он)
13. Биоаюулгүй байдлын тухай Картагены протокол 2002 он
14. Монголын гаалийн хөгжлийн концепц.
15. Ургамал хамгаалах олон улсын конвенц
16. Bioterrorism act of US. 2002
17. Food law of EU. European Commission 2002.

**Ном зохиол**

18. John M. Antle. Choice and Efficiency in Food Safety Policy, ISBN-10: 0844739022
19. Csaba Csaki ets. Food and Agricultural Policy in Russia, The World Bank technical paper #523. 2002 ISBN-0-82135177-x
20. Donald J. MacKenzie and Morven A. McLean. Agriculture and the WTO, The World Bank, Fact book 2004. A Primer for Policymakers,
21. Rachel Slater, Simon Maxwell. Food Policy Old and New, ISBN-10: 1405126027
22. Robert L. Paarlberg. The Politics of Precaution: Genetically Modified Crops in Developing Countries (International Food Policy Research Institute), ISBN-13: 978-08018682
23. Philip G. Pardey. The Future of Food: Biotechnology Markets and Policies in an International Setting (International Food Policy Research, ISBN-13: 978-0896297098
24. World Bank Technical Paper #469. Food Safety Issues in Developing Countries. ISBN: 0-8213-4770-5
25. Гомбо Г. Монголчуудын хоол хүнсний уламжлал, шинэчлэл 2005. 243-324 хуудас
26. Дамдинсүрэн Л. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын тулгамдсан зорилтууд. илтгэл 2002 он.
27. Буудайхүү Д. "Орчин үеийн биотехнологийн хэрэглээнд үйлчилж болох хууль зүйн тойм ба үнэлгээг хамруулсан биотехнологийн хэрэглээ, биотехнологийн найдвартай хэрэглээний зохицуулалтын судалгаа" 2002 он.
28. Дашням Б., Батаа Н. "Өөрчлөгдсөн амьд бие махбодь (ӨАБ)ба арилжааны бүтээгдэхүүнийг байгаль, нийгэмд гаргах үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллийн судалгаа", 2003 он.
29. "НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын хамтарсан хүнсний хууль эрхзүйн комисс ба хамтын ажиллагаа" семинарын материалууд.
30. Хүнсний үйлдвэрийн өрсөлдөх чадвар. Онол практикийн бага хурал. Материалууд. 2007 он.
31. Цэцгээ Х. Хүнсний аюулгүй байдлыг төрийн гаалийн бодлогоор хамгаалах нь. Өдрийн сонин. 2007.06.04. -2581. 129
32. ЭМЯ, ЭМХҮТ. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд. 2003-2006.
33. ХХААЯ, ЭМЯ. Хүнсний бохирдлын түвшиний судалгаа. 2006
34. ЭМЯ, UNICEF. Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал
35. СТГ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2002-2006.
36. УГЕГ. Гадаад Худалдааны Гаалийн Статистик Мэдээлэл. 2002-2007 он 9 сар

### Веб материал

37. <http://www.ipbo.ugent.be/> Institute of Plant Biotechnology for Developing Countries
38. [http://www.codexalimentarius.net/web/index\\_en.jsp](http://www.codexalimentarius.net/web/index_en.jsp) FAO/WHO Food Standards principles for Risk Analysis and Guidelines for Safety Assessment of Foods derived from Modern Biotechnology
39. <http://www.food.gov.uk/foodindustry/regulation/ria/ria2004/gmria> Food Standards Agency UK
40. <http://www.fao.org/biotech/index.asp?lang=en> Food and Agriculture
41. <http://www.ifpri.org/> International Food Policy Research Institute
42. <http://www.fao.org/biotech/index.asp?lang=en> Food and Agriculture Organization of the UN  
<http://www.fao.org/countryprofiles/lifdc.asp?lang=en> (LIFDC list)
43. <http://www.fda.gov/>  
<http://www.fda.gov/ora/import/default.htm>  
[http://www.fda.gov/ora/inspect\\_ref/default.htm](http://www.fda.gov/ora/inspect_ref/default.htm)  
[http://www.fda.gov/ora/compliance\\_ref/default.htm](http://www.fda.gov/ora/compliance_ref/default.htm)  
<http://www.fda.gov/oc/bioterrorism/bioact.html>  
<http://www.fda.gov/oc/initiatives/advance/food.html> Food Protection Plan
44. <http://www.cfsan.fda.gov/list.html>, <http://www.fda.gov/> US Food and Drug Administration, Center for Food Safety and Applied Nutrition
45. <http://www.fda.gov/oc/bioterrorism/PL107-188.html#title3> Chapter III Protecting Safety and Security of Food and Drug Supply
46. [http://www.fsis.usda.gov/Regulations\\_&\\_Policies/index.asp](http://www.fsis.usda.gov/Regulations_&_Policies/index.asp) Food Safety and Inspection Service Products for Personal Consumption
47. [http://www.iso.org/iso/standards\\_development.htm](http://www.iso.org/iso/standards_development.htm) International Organization for Standardization
48. <http://ifia-federation.org/> International Federation of Inspection Agency
49. <http://www.inspection.gc.ca/english/toce.shtml> Canadian Food Inspection Agency
50. <http://www.who.int/foodsafety/en/> World Health Organization. Food safety issues
51. [http://ec.europa.eu/food/food/foodlaw/principles/index\\_en.htm](http://ec.europa.eu/food/food/foodlaw/principles/index_en.htm), Food Law of EU
52. [http://www.efsa.europa.eu/EFSA/efsa\\_locale-1178620753812\\_home.htm](http://www.efsa.europa.eu/EFSA/efsa_locale-1178620753812_home.htm) European Food Safety Authority (EFSA) The Rapid Alert System for Food and Feed (RASFF)